



Монгол улс дахь хүүхэд
хамгааллын үйлчилгээний
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ, зардлын
ТООЦООЛОЛ

Тайлан

Бэлтгэсэн:

Г. Энхтүвшин
Үндэсний зөвлөх

Нью Фронттиерс ХХК
Утас: +976 9999-2578
Э-мэйл: enkhtuvshin@newfrontiers.mn

Конрад Барбертон
Олон улсын зөвлөх

Корнерстоун эдийн засгийн судалгаа
Утас: +27 12 329 5562
Э-мэйл: conrad@cornerstonesa.net

2015 оны 2 сар

ТАЛАРХАЛ

Бид ХХТХ-ын зардал тооцооллыг гаргах хэрэгцээ шаардлага буйг тодорхойлж, зөвлөх үйлчилгээний туршид дэмжлэг үзүүлсэн НҮБ-ийн Хүүхдийн Сангийн Монгол дахь салбар болон Тайландад байрлах Бүсийн оффист юун түрүүнд талархал илэрхийлж байна.

Мөн бид төслийн явцад тооцоолол чухал шаардлагатай мэдээлэл, болон өгөгдөл хуваалцаж дэмжлэг үзүүлсэн дараах байгууллагуудын удирдлага, ажилтнуудад талархал илэрхийлж байна. Үүнд:

- ХАХНХЯ-ны Хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын, Гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжлийн хэлтэс
- ХАХНХЯ-ны Нийгмийн хамгааллыг бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- СЯ-ын Төсвийн бодлогын газрын, Төсвийн зарлагын хэлтэс
- Хүүхдийн төлөө үндэсний газар, УБ хотын Багануур дүүргийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Сүхбаатар, Дорноговь аймаг, УБ хотын, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, газар
- Замын-Үүд сумын Засаг дарга, нийгмийн бодлогын хэлтэс, дунд сургуулиудын нийгмийн ажилтан, цагдаагийн газрын хүүхдийн байцаагч
- Хүүхдийн тусламжийн утас 108-н координатор

Түүнчлэн 2015 оны 10 сарын 19-21-д Улаанбаатар хотод явагдсан Зардал тооцооллын аргачлалын сургалтад хамрагдаж идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн оролцогчдод талархал илэрхийлье.

Лесота улсын 2011 оны Хүүхэд хамгаалал, халамжийн хуулийн зардлыг тооцох загвартай танилцах боломж олгож, зардлын тооцоолох явцад зөвлөгөө өгч байсан Корнестоун Эдийн Засгийн Судалгаа компанид Үндэсний зөвлөх Г. Энхтүвшин мөн талархал илэрхийлж байна.

Зөвлөхийн баг

ХУРААНГУЙ

Монгол улсын Засгийн Газраас Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхээр УИХ-д 2015 оны 5 сард өргөн барьж, 2016 оны 2 сарын 5-д хууль УИХ-аар батлагдсан. Хүүхэд хамгааллын тухай хууль (“ХХТХ”) УИХ-аар хэлэлцэгдэж буйтай холбогдуулан шийдвэр гаргагчдыг уг хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн талаар бодитой мэдээллээр хангах үүднээс НҮБ-ын Хүүхдийн Сангаас “Монгол улс дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн шинжилгээ, зардлын тооцоолол” сэдэвт зөвлөх үйлчилгээг захиалан хийлгүүлсэн. Энэхүү тайлан болон дагалдах зардал тооцооллын загвар нь зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэсэн олон улсын болон үндэсний мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх багийн ажлын гол үр дүн юм. Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийсэн ажил хоёр үндсэн чиглэлээр явагдсан.

Нэгдүгээрт, хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцооны санхүү болон хүний нөөцийн байдалд дүгнэлт өгсөн. Хэдийгээр Монгол улс 2015 онд улсын төсвийн зарлагын 5%, ДНБ-ний 1.5%-тай тэнцэх хэмжээний буюу 332 тэрбум гаруй төгрөгийг хүүхэд чиглэсэн хөтөлбөрүүдэд зарцуулсан боловч үүний 9.0 тэрбум орчим нь л хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд тухайлан зарцуулагдсан бөгөөд бусад нь Хүүхдийн мөнгө зэрэг нийгмийн арга хэмжээнд зориулагдсан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн (“ХГБХ”) байгууллагуудын төсвийн хүрэлцээ маш хангалтгүй бөгөөд тэдний төсвийн дунджаар 95% нь ажиллагчдын цалин болон барилга байшингийн халаалт, цахилгаан зэрэг хүүхэд хамгаалалтай шууд холбогдолгүй зардлуудыг төлөхөд зориулагддаг байна. ХГБХ байгууллагуудад хүүхэд хамгааллын үйл ажиллагааны нэн чухал хэсэг болох албан байгууллагаас гадагш гарч газар дээр нь ажиллах зардал бараг байдаггүй.

Хоёрдугаарт, ХХТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг “хэмнэлтийн”, “өсөлтийн” болон “дундын” гэсэн гурван хувилбараар тооцсон. Хүснэгт 1-д үзүүлснээр ХХТХ-ийг хэрэгжүүлэх нийт зардал “хэмнэлтийн” хувилбараар 4.3 тэрбум төгрөг, “дундын” хувилбараар 11.5 тэрбум төгрөг, “өсөлтийн” хувилбараар 21.1 тэрбум төгрөг болохоор байна.

Хүснэгт 1: ХХТХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын тооцоолол

Зардлууд	сая. төг		
	Хувилбар 1 (Дундын)	Хувилбар 2 (Өсөлтийн)	Хувилбар 3 (Хэмнэлтийн)
Нийт	11,473	21,126	4,305
Нэг удаагийн зардал	2,314	4,536	402
Урсгал зардал	9,159	16,590	3,903

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Зохиогчдын үзэж буйгаар “Дундын” хувилбар нь өнөөгийн нөхцөлд хэрэгжүүлэх хамгийн боломжтой хувилбар юм. Энэ хувилбараар хүүхдийн эсрэг хүчирхийллийн

илрүүлэлт дунд зэрэг сайжирч, хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт нэмэгдэх бөгөөд ХГБХ-ийн байгууллагын орон тоон аймгаас дээш түвшинд бага хэмжээгээр нэмэгдүүлнэ гэсэн төсөөллийг ашигласан. Харин төсвийн боломж нэмэгдсэн үед энэ хувилбараар эхлэлийг нь тавьсан үйл ажиллагаануудын цар хүрээг өргөжүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээг харьцангуй өргөн хүрээнд явуулахаар тооцсон Хувилбар 2-ын түвшинд хүргэх боломжтой бөгөөд энэ явцад жил бүрийн зардлууд ямар байхыг мөн тооцоолсон.

Хүснэгт 1-д үзүүлсэн зардлын дүнгийн талаар зарим тодруулгыг хийх шаардлагатай. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь зөвхөн ХХТХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг тооцоход чиглэгдсэн бөгөөд хүүхдийн бүх эрхийг хамгаалахад шаардлагатай зардал биш юм. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд бүрэн дунд хүртэл түвшний боловсролыг үнэ төлбөргүй эзэмшихээр заасан. Хэрэв ойр орчимд нь дунд сургууль байхгүйгээс хүүхэд сургуульд явж эрхээ эдэлж чадахгүй байгаа тохиолдолд, тухайн хүүхдийг сургуульд явах боломжоор хангах асуудал ХХТХ-тай холбоогүй тул зардал нь тооцогдоогүй. Үүний мөн адил хэрэв хүүхэд эцэг эхтэйгээ гэртээ хүчирхийллээс ангид амьдардаг боловч, гэр бүл нь ядуурлын шугамаас доогуур орлоготой, үүнээсээ шалтгаалан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийлгэж чаддаггүй бол ийм үзлэг оношилгоо хийлгэх боломжоор хангахтай холбоотой зардал энд тооцогдоогүй.

ХХТХ нь шинээр батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хууль болон УИХ-д өргөн баригдаад буй Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай харилцан уялдаатай. Жишээлбэл ХХТХ-ийн дагуу Төрөөс хүргэх хүүхэд хамгааллын зарим үйлчилгээ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар бий болох интитуцийн бүтцээр дамжин хүргэгдэнэ. Эдгээр хуулиуд нь мөн хүүхэд хамгаалалтай шууд холбоотой гадаадын болон Монгол улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх зэрэг харилцааг зохицуулдаг. Эдгээр хуулиуд нь мөн хүүхэд хамгаалалтай шууд холбоотой гадаадын болон Монгол улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх зэрэг харилцааг зохицуулдаг.

ХХТХ-ын явагдах хүүхэд хамгаалал нь Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудад заасан хүүхдийн эрх, сайн сайхан байдлыг хэмжих олон үзүүлэлтийн зөвхөн нэг хэсэг нь юм. Түүнчлэн хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн хамгаалал нь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэлтэй шууд холбоотой бөгөөд эдгээр үйл ажиллагаанууд бүгд нэг байгууллагаар буюу ХГБХБ-аар дамжин хэрэгжиж байгаа нөхцөлд үйл ажиллагаа тус бүрд зарцуулагдаж буй төсөв зардлыг ялгаж тооцох нь амаргүй. Эдгээрт үндэслэн хүүхэд, гэр бүлийн холбогдолтой шинээр батлагдсан буюу шинэчлэн найруулагдах бүх хуулийг хамарсан зардлыг тооцооллыг хийх нь төсөв зохиогчдын хувьд ач холбогдолтой байх болно.

ГАРЧИГ

Талархал.....	1
Хураангуй	2
Товчлол.....	6
Хүснэгтийн жагсаалт	7
Зургийн жагсаалт	7
Оршил	8
Хэсэг 1: Хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоо	11
1.1 Зохион байгуулалт, санхүү, хүний нөөц	11
1.1.1 Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөл.....	11
1.1.2 Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яам	11
1.1.3 Хүүхдийн төлөө үндэсний газар	12
1.1.4 Хүүхдийн Тусламжийн утас 108	13
1.1.5 Улаанбаатар хотыг ХГБХ-ийн Газар.....	16
1.1.6 Аймгуудын ХГБХ-ийн хэлтэс.....	17
1.1.7 Сум, хорооны нийгмийн ажилтнууд.....	20
1.1.8 Сургуулийн нийгмийн ажилтан.....	21
1.1.9 Нийслэлийн цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс	21
1.2 Асрамжийн газрууд.....	21
1.2.1 Өнөр бүл төв.....	21
1.2.2 Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор.....	22
1.2.3 Хүүхдийн сувилал	22
1.2.4 Энэрэл төв	22
1.2.5 ТББ, хувийн санхүүжилттэй бусад асрах төвүүд	22
1.3 Түр хамгаалах байрууд	23
1.3.1 Нийслэлийн цагдаагийн газрын дэргэдэх түр хамгаалах байр.....	23
1.3.2 Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн дэргэдэх хамгаалах байр.....	23
1.3.3 Аймгийн төвүүд дэх хамгаалах байр.....	23
1.4 Хүүхдийн халамж, хамгаалалд зориулж буй Засгийн Газрын бусад зардлууд	23
1.4.1 Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу олгогддог тэтгэмжүүд	23
1.4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогддог тэтгэмж, тусламж	25
1.4.3 Хүүхдийн мөнгө.....	25
1.5 Засгийн Газраас хүүхэд хамгаалалд зориулж буй зардлын нэгтгэл.....	26

ХЭСЭГ 2: Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зардлын тооцоолол.....	29
2.1 Оршил.....	29
2.2 Зардал тооцооллын загварын онцлогууд.....	31
2.3 Зардлын тооцооллын үр дүн.....	35
2.3.1 Томоохон зардлууд – Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ.....	38
2.3.2 Томоохон зардлууд – ХГБХБ-ын чадавхыг бэхжүүлэх.....	39
2.4 Үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөө.....	40
2.5 Зардлын төрлүүд.....	42
2.6 Хувьсах зардал.....	43
Хэсэг 3: Дүгнэлт.....	45
Ашигласан материал.....	47
Хавсралт 1: Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх процессын зураглал.....	48
Хавсралт 2: Зардлын тооцоололд хамрагдсан үйлчилгээнүүд.....	51

ТОВЧЛОЛ

ЗГ	Засгийн Газар
НХХ	Нийгмийн халамжийн тухай хууль
НХҮЕГ	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХГБХБ	Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн байгууллага
ХГБХТ	Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн төв (Улаанбаатар хотын 9 дүүргийн)
ХГБХХ	Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн хэлтэс (аймгуудын)
ХГБХГ	Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар (Улаанбаатар хотын)
ХХТХ	Хүүхэд хамгааллын тухай хууль
ХБИНХТХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамжийн тухай хууль
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
СЯ	Сангийн Яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: ХХТХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын тооцоолол	2
Хүснэгт 2: ХТҮГ-ын орон тоо, төсөв, сая төгрөгөөр	13
Хүснэгт 3: Оролцогч талуудын хүүхэд хамгааллын талаар хүлээсэн үүрэг	14
Хүснэгт 4: Хүүхдийн тусламжийн утас 108-ын 2015 онд хүлээн авсан дуудлага	15
Хүснэгт 5: Тусламжийн утас 108-д ирсэн хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлагууд.....	15
Хүснэгт 6: Улаанбаатар хотын ХГБХБ-ын төсөв.....	16
Хүснэгт 7: Аймгуудын ХГБХ-ийн хэлтсүүдийн 2015 оны төсөв, орон тоо	17
Хүснэгт 8: ХГБХ-ийн байгууллагуудын ажиллагсдын болон бусад гол урсгал зардлууд	18
Хүснэгт 9: ХГБХ-ийн байгууллагуудын гол урсгал зардлууд, 2015 оны төсөв, сая төгрөгөөр	19
Хүснэгт 10: ХГБХ-ийн байгууллагуудын тээвэр, дотоод томилолтын зардал, 2015 оны төсөв	20
Хүснэгт 11: Өнөр бүл төвийн 2015 оны төсөв	21
Хүснэгт 12: Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу олгогддог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжүүд.....	24
Хүснэгт 13: ХБИНХТХ-ийн дагуу олгогддог тусламж, тэтгэмжүүд.....	25
Хүснэгт 14: Хүүхдийн мөнгөний олголт.....	26
Хүснэгт 15: Засгийн газраас зарцуулж буй хүүхэдтэй холбоотой зардлууд.....	27
Хүснэгт 16: Хүүхэд хамгаалалд зарцуулагдаж буй санхүү, хүний нөөц	28
Хүснэгт 17: Зардалд нөлөөлж буй гол хүчин зүйлс	35
Хүснэгт 18: ХХТХ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хураангуй	35
Хүснэгт 19: Нэг удаагийн зардлын хураангуй.....	36
Хүснэгт 20: Урсгал зардлын хураангуй	37
Хүснэгт 21: Хүүхэд асрах төвийн нэг хүүхдэд ногдох зардал	39
Хүснэгт 22: Хувилбар 1-ээс 2-т үе шаттайгаар шилжих үеийн зардлын хуваарь	40
Хүснэгт 23: Нийт зардлын задаргаа.....	42
Хүснэгт 24: Хувилбар 1-ээс 2-д шилжих үеийн нийт зардал	42
Хүснэгт 25: Нэг хүүхдэд ногдох хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлын тооцоолол, улсын дунджаар	44

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан гол байгууллагуудын бүтцийн схем	12
Зураг 2: Гэр бүлийн тухай хуулиар бий болох ХГБХБ-ын бүтцийн зураглал.....	32
Зураг 3: Нийт зардлын бүтэц, Хувилбар 1-ээр.....	38
Зураг 4: Хувилбар 1-ээс 2-т үе шаттайгаар шилжих үеийн зардлууд.....	41
Зураг 5: Хамгаалаа шаардлагатай хүүхдэд үйлчилгээ хүргэх процесс.....	48
Зураг 6: Монгол улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх процесс.....	49
Зураг 7: Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх процесс /.....	50

ОРШИЛ

Хэдийгээр Монголчууд үр хүүхдэдээ зөөлнөөр хандаж өсгөж хүмүүжүүлэх түүхэн уламжлалтай боловч, хүүхдийн эрхийн зөрчил, бие махбодын хүчирхийлэл сүүлийн жилүүдэд санаа зовоосон нийгмийн асуудал болон хувирч байна. Үүний шалтгаан нь ядуурал, архидалтаас зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдээс гадна, олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаах ойлголт, мэдээлэл муу, хүүхэд хамгаалах тогтолцоо сайн бүрдээгүйтэй холбоотой. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн тоо 2007-2014 оны хооронд 37 хувиар өсөж 1 576-д хүрсэн. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогчдын дийлэнх нь бага насны хүүхдүүд байгаа бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон 7 хүртэл насны хүүхдийн тоо 2007-2014 онуудад нийт 69 хувиар нэмэгдсэн байна¹.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн конвенцэд нэгдсэн орны хувьд Монгол улс хүүхдийн эрх, хүүхэд хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг хүлээдэг. Гэвч хүүхэд хамгаалалтай холбоотой олон асуудлууд хуулиар зохицуулагдаагүй, хүүхэд хамгаалалд оролцох үүрэг хүлээсэн байгууллагууд үүргээ зохих хэмжээнд биелүүлэх төсөв, санхүүгийн боломж хомс явж ирсэн.

Ийм нөхцөл байдалд Монгол улсын Засгийн Газраас Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэхээр УИХ-д 2015 оны 5 сард өргөн барьсан. УИХ-аас хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын 5 гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг, холбогдох байгууллагуудын төлөөлөл болох 19 гишүүнтэй ажлын дэд хэсгийг тус тус байгуулсан. УИХ дээрх хэлэлцүүлгийн явцад хуулийн төсөл анх өргөн баригдсанаас нэлээд хэмжээгээр өөрчлөгдөж 2015 оны 2 сарын 5-д УИХ-аар батлагдсан.

Хүүхэд хамгааллын тухай хууль ("ХХТХ") батлагдахтай холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн Сангаас хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөв, зардлын тооцооллыг хийх зорилгоор олон улсын болон үндэсний зөвлөхийн багийг ажиллуулсан бөгөөд олон улсын зөвлөх нь зардал тооцооллын аргачлал, сайн жишгийн талаар сургалт зохион байгуулж, үндэсний зөвлөхөд техникийн зөвлөгөө өгөх үүрэгтэйгээр, үндэсний зөвлөх нь зардлыг тооцооллыг хийж энэхүү тайланг бэлтгэх үүрэгтэйгээр оролцсон. Мөн олон улсын зөвлөх нь зардлын тооцоолол болон тайланг хянан үзэж эцсийн тайланг магадалсан болно.

Зардлын тооцооллыг хийхдээ үндэсний зөвлөх нь Монгол улсын хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоо, хүүхэд хамгаалах чиглэлээр үүрэг хүлээсэн байгууллагуудын төсөв санхүү, хүний нөөцийн байдал, хүүхдийн хүчирхийллийн нөхцөл байдлын судалгаа хийж, тоон мэдээлэл цуглуулсан. Мэдээллийг тухайн чиглэлээр гарсан тайлан, судалгаануудаас гадна холбогдох байгууллагуудтай ярилцлага хийх болон

¹ Эх сурвалж: Статистикийн Мэдээллийн Сан 1212.mn, Хүснэгтийн ID: DT_NSO_2300_017V1, Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар

аймаг сумдад НҮБ-ын Хүүхдийн Сан, ХАХНХЯ-ны төлөөллөөс бүрдсэн багаар ажиллах явцад цуглуулсан.

ХХТХ-ийн зэрэгцээ УИХ-аар Хүүхдийн эрхийн тухай хууль² болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Гэр бүлийн тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байна. Эдгээр хуулиуд нь ХХТХ-тай нягт уялдаатай бөгөөд ХХТХ-ийн дагуу хийгдэх хүүхэд хамгааллын ажлыг хийж гүйцэтгэх байгууллагын бүтэц, санхүү болон хүний нөөцтэй холбоотой чухал асуудлууд Гэр бүлийн тухай хууль болон, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудаар зохицуулагдаж байна. Үүнээс шалтгаалан зардлын тооцооллыг хийхдээ зөвхөн ХХТХ төдийгүй бусад гурван хуулийн холбогдох зохицуулалтуудыг харгалзан үзэх шаардлагатай болсон. Мөн хууль батлагдсантай холбоотойгоор авч хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын арга хэмжээний далайц нь тухай үеийн төсвийн байдлаас хамаарна. Эдгээрийг харгалзан үзэж зардлын тооцооллыг “хэмнэлтийн”, “дундын”, “өсөлтийн” гэсэн гурван хувилбараар гаргасан.

ХХТХ-ыг хэрэгжүүлэхэд “хэмнэлтийн” буюу хамгийн бага зардалтай хувилбараар 4.3 тэрбум төгрөг, “дундын” хувилбараар 11.5 тэрбум төгрөг, “өсөлтийн” буюу хамгийн өндөр зардалтай хувилбараар 21.1 тэрбум төгрөг шаардагдахаар байна. Эдгээр нь одоогоор хүүхэд хамгааллын ажилд зарцуулагдаж буй 9.0 тэрбум төгрөг дээр нэмж гарах зардал юм.

Зардлын тооцооллын хамрах хүрээ нь зөвхөн хүүхэд хамгааллын арга хэмжээгээр хязгаарлагдаж байгаа тул дээрх зардлууд нь хүүхдийн бүх эрхийг хамгаалахад шаардагдах зардал биш болохыг энд онцлох шаардлагатай. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдүүд ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй гэж заасан боловч ойр орчимд нь сургууль байхгүйгээс хүүхэд сургуульд явж чадахгүй байгаа тохиолдолд түүнийг сургуульд хамруулах зардал нь хүүхэд хамгаалалтай шууд холбоогүй тул энэхүү зардлын тооцоололд тусгагдаагүй болно.

Түүнчлэн зардал тооцооллын хамгийн өндөр зардалтай хувилбарт ч зардлын хэмнэлт болон бодит амьдралд тохиолддог жишгийг харгалзан үзэж төсвийг аль болох хэмнэлтгүйгээр гаргах чиглэлийг баримталсан. Жишээлбэл, ХГБХБ-ын ажилтан хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирж сургалтад хамрагдах үед тээврийн зардлыг “нэг хүн-нэг машин” жишгээр биш харин хот хоорондын автобусанд төлөх зардал, эсвэл хэд хэдэн хүн хамтарч нэг машинаар ирэхээр тооцож хийсэн. Иймд эдгээр хувилбаруудаар тооцсон зардлын дүнг хувилбар тус бүр дээр гарч болох зардлын доод хэмжээ гэж үзэж болно. Энэхүү тайланг MS Excel дээр хийгдсэн зардал тооцооллын загвар дагалдах бөгөөд цаашид гол параметр болон өгөгдлүүд өөрчлөгдөх тохиолдолд загвард холбогдох өөрчлөлтийг хийж тооцооллыг шинэчлэх боломжтой.

² Энэ хууль нь УИХ-аар 2016 оны 2 дугаар сарын 6-д батлагдсан

Энэхүү тайлан нь дараах байдлаар зохион байгуулагдсан. Хэсэг 1-д хүүхэд хамгааллын өнөөгийн тогтолцоо, хүүхэд хамгааллын байгууллагуудын санхүү, хүний нөөцийн байдлыг авч үзэж, хүүхэд хамгаалалд зарцуулагдаж буй нийт зардлыг тооцсон. Хэсэг 2-д зардал тооцооллын загвар, тооцооллын талаар товч мэдээлэл болон тооцооллын үр дүнг танилцуулсан. Зардлын тооцоололд ашигласан ихэнх мэдээллийн эх сурвалж болон төсөөллүүдийг тооцооллын загвараас харж болно. Хэсэг 3-д тайланг дүгнэсэн болно.

ХЭСЭГ 1: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО

1.1 Зохион байгуулалт, санхүү, хүний нөөц

Орон тооны бус гишүүдээс бүрдсэн Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг эс тооцвол одоогоор Монгол улсад хүүхэд хамгааллын асуудлыг тусгайлан хариуцсан байгууллага байхгүй бөгөөд үндэсний болон орон нутгийн түвшинд хүүхэд гэр бүлийн холбогдолтой бүх асуудлыг нэгтгэн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагууд хариуцдаг. Зураг 1-д хүүхэд хамгааллын одоогийн систем дэх гол байгууллагуудын бүтцийн схемийг дүрслэн харуулав. Хэдийгээр хүүхэд хамгааллын асуудалд оролцоотой байгууллагууд дээд шатандаа босоо удирдлагын тогтолцоотой боловч орон нутгийн түвшинд орон нутгийн удирдлагаас хамааралтай. Улаанбаатар хотын ХГБХ-ийн газар болон дүүргүүдийн ХГБХ-ийн төвүүдийн удирдлагыг УБ хотын болон дүүргүүдийн Засаг дарга, аймгуудын ХГБХ-ийн хэлтсийн удирдлагыг аймгийн Засаг дарга тус тус томилдог. Харин сумдад нийгмийн бодлого хариуцсан ажилтнууд сумын Засаг даргын удирдлагад байдаг. Шат шатны байгууллагуудын хүүхэд хамгааллын асуудалд оролцоог оролцоог Хүснэгт 3-д тоймлон харуулав.

Дарах хэсэгт Зураг 1-д харуулсан хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн гол байгууллагууд болон Хүснэгт 3-д дурдсан байгууллагуудын гүйцэтгэх үүргийн талаар авч үзэв.


1.1.1 Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөл

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай 1996 онд батлагдсан хуульд зааснаар Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөл нь (“ХТҮЗ”) хүүхдийн хөгжил, хамгааллын талаар баримтлах Төрийн бодлогыг боловсруулах үүрэг хүлээсэн дээд байгууллага юм. ХТҮЗ-ийг Ерөнхий сайд даргалж, гишүүдийг нь томилдог бөгөөд ХТҮГ нь зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. ХТҮЗ нь 1994 оноос хойш орон тооны ажилтантай байгаагүй.

1.1.2 Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яам

Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ) нь хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага юм. Тус яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжлийн хэлтэст хүүхэд хамгааллын асуудал харьяалагддаг бөгөөд тус хэлтэс нь хүүхдийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх асуудал хариуцсан нэг мэргэжилтнийг оролцуулан нийт 5 ажилтантай.

Зураг 1: Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан гол байгууллагуудын бүтцийн схем



Тайлбар:

- ХАХНХЯ-ын сайдын багцад төсөв нь батлагддаг
- Нийслэлийн ЗД-ын багцад төсөв нь батлагддаг
- Аймгуудын ЗД-ын багцад төсөв нь батлагддаг

1.1.3 Хүүхдийн төлөө үндэсний газар

Хүүхдийн төлөө үндэсний газар (ХТҮГ) нь Хүүхэд, Гэр бүлийн асуудал хариуцсан Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг юм. ХАХНХЯ-ны сайдын баталсан тушаалаар³ ХТҮГ-ын орон тоог 35 хүнээр, түүний дотор Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн бодлогыг

³ 2015 оны 5 сарын 5-ны А/68 тоот тушаал

хэрэгжилтийн газар 8 ажилтантай байхаар баталсан. Хүснэгт Хүснэгт 2-д ХТҮГ-ын сүүлийн жилүүдийн орон тоо болон төсвийг харуулав.

Хүснэгт 2: ХТҮГ-ын орон тоо, төсөв, сая төгрөгөөр

	2013	2014	2015
Үндсэн болон нэмэгдэл цалин, ажиллагсадтай холбоотой зардлууд	309	461	501
Бараа үйлчилгээний зардал	1,290	1,058	1,210
Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратегийг хэрэгжүүлэх	594	355	355
Хүүхдийн тусламжийн утас 108	-	-	188
Шилжүүлэг болон тэтгэмжүүд	25	54	11
Нийт зардал	1,624	1,572	1,722
Орон тоо	34	34	34

Эх сурвалж: ХТҮГ

ХГБХБ-ууд дунд ХТҮГ нь хүүхэд хамгаалалд зориулсан төсөвтэй цорын ганц байгууллага юм. Хүснэгт Хүснэгт 2 харуулсан “хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги”-ийг хэрэгжүүлэх төсөв Засгийн Газрын 2011 оны 347 тоот тушаалаар батлагдсан стратегийг хэрэгжүүлэх зорилгоор төсөвлөгдсөн бөгөөд ХТҮГ-ын тайлбарласнаар ихэвчлэн эрсдэлд өртсөн хүүхдийг аюулгүй газар байрлуулах, өмгөөлөгч авах зэрэг хүүхэд хамгаалалтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулагддаг. Гэвч энэ төсвөөс санхүүжигдэх үйл ажиллагаа нь ихэвчлэн Улаанбаатар хотод гардаг байна.

ХТҮГ-ыг харьяанд мөн хүүхэд асрах Өнөр бүл төв, Найрамдал зуслан болон Хүүхдийн тусламжийн утас 108 ажилладаг. Найрамдал зуслан нь хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай шууд холбоогүй бөгөөд Өнөр бүл төв болон Тусламжийн утас 108 талаар доор тусгайлан авч үзсэн.

1.14 Хүүхдийн Тусламжийн утас 108

Тусламжийн утас нь 2014 оны 6 сард Мобиком корпораци болон Дэлхийн Зөн байгууллагын тусламжаар байгуулагдсан. Координатор, ахлах зөвлөх, 4 ээлжийн ахлагч, болон 15 зөвлөх, нийт 21 гэрээт ажилтантай үйл ажиллагаа явуулж 24 цагаар дуудлага хүлээн авдаг. Тус нэгж нь 2015 онд 188 сая төгрөгийн төсөвтэй ажилласан бөгөөд энэ нь зөвхөн ажилтнуудын үндсэн цалингийн зардлын төлөхөд хүрэлцдэг, бусад үйл ажиллагаанд ямар нэгэн зардал төсөвлөгдөөгүй байна. Гэтэл тус нэгжийн төсөв 2016 онд 168 сая төгрөг болж буурсан нь орон тооны цомхотгол хийхэд хүргэж болзошгүй.

Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийг бүртгэх бүртгэлийн систем нь Мобиком корпорацийн тусламжаар хийгдсэн бөгөөд програм хангамжийг анхнаасаа гурван үе шаттайгаар хөгжүүлэхээр төлөвлөсөн боловч одоогоор зөвхөн эхний хоёр шатны

хөгжүүлэлт хийгдээд байна. Тусламжийн утсанд шаардлагатай тоног төхөөрөмж, компьютерүүд нь Дэлхий Зөн байгууллагын хандиваар олгогдсон, одоогоор хуучирч муудсанаас цаашдын хэвийн үйл ажиллагааг хангахад компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэх, нөөц тоног төхөөрөмжийг бэлтгэх шаардлагатай.

Хүснэгт 3: Оролцогч талуудын хүүхэд хамгааллын талаар хүлээсэн үүрэг

Хариу үйлчилгээ	Оролцогч талууд
Илрүүлэлт	ХТҮГ-ын Тусламжийн утас 108 Мэдээлэл хүлээн авагч: i) Тусламжийн утас, ii) Цагдаа, iii) Хамтарсан баг, нийгмийн ажилтан (хороо/сумын), iv) Сургуулийн нийгмийн ажилтан, v) Аймаг, дүүрэг, нийслэлийн ХГБХБ-ын ажилтнууд
Судалгаа/Шалгалт	1. Хамтарсан багийн гишүүд (Өрхийн эмч, цагдаа), нийгмийн ажилтан (сум, хорооны); 2. Сургуулийн нийгмийн ажилтан 3. Аймаг, дүүрэг, нийслэлийн ХГБХБ-ын ажилтнууд
Үнэлгээ	1. Сум хорооны нийгмийн ажилтан; 2. Сургуулийн нийгмийн ажилтан; 3. Аймаг, дүүрэг, нийслэлийн ХГБХБ-ын ажилтнууд;
Яаралтай тусламж	Яаралтай тусламжийг Улаанбаатар хотод байрлах дараах эмнэлгүүд хүргэдэг: 1. Гэмтэл согог судлалын үндэсний төв 2. Шүүх эмнэлэг 3. Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг (Эдгэр нь зөвхөн хүүхдэд зориулсан эмнэлгүүд биш юм) Орон нутагт, Завхан Говь-Алтай зэрэг зарим аймагт ийм төрлийн үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүд байдаг
Кэйс менежмент	Нийслэл, аймаг, дүүрэг сумын Засаг дарга нар нь эцэг, эх, асран хамгаалагчийн хараа хяналтгүй хүүхдүүдийг гэмт хэрэгт холбогдох, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, эмзэг болон эрсдэлтэй нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийн талаар мэдээлэл цуглуулах үүрэгтэй
<ul style="list-style-type: none"> • Холбон зуучлах • Нөхөн сэргээх • Аюулгүй газар байршуулах • Гэр бүлд нь нэгтгэх • Хянах, эргэх холбоо 	Сум, дүүргийн засаг дарга нар хүүхдийг байнгын асрах төвд шилжүүлэх шийдвэрийг гаргадаг.
Үрчлэлт (дотоодын)	i) Орон нутгийн Засаг захиргаа, ii) Шүүх
Үрчлэлт (гадаадын иргэнд)	i) Иргэний бүртгэл шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, ii) ХАХНХЯ
Бүртгэл	Улсын бүртгэлийн ерөнхий газар
Насанд хүрээгүй хүүхдүүдэд үзүүлэх хорихоос бусад шийтгэл	i) Цагдаа, ii) Прокурор, iii) Шүүх, iv) Шүүхийн шийдвэр биелүүлэх газар, v) Орон нутгийн засаг захиргаа, vi) ХГБХБ-ууд

Эх сурвалж: НҮБ-ын Хүүхдийн Сан

Хүүхдийн тусламжийн утас 108 нь 2014 оны 6 сарын 1-д байгуулагдсанаасаа хойш 2015 оны 10 сарын 31-ий байдлаар нийт 255,969 дуудлагыг хүлээн авсан. Хүснэгт 4-өөс үзэхэд, үйл ажиллагаагаа явуулсан эхний бүтэн жил болох 2015 оны дүнгээс үзэхэд нийт дуудлагын 35 хувийг зорилтот, 65 хувийг зорилтот бус дуудлага эзэлж байна

Хүснэгт 4: Хүүхдийн тусламжийн утас 108-ын 2015 онд хүлээн авсан дуудлага

	Дуудлагын тоо	Зорилтот дуудлагад эзлэх хувь	Нийт дуудлагад эзлэх хувь
Зорилтот дуудлага	55,889	100.0%	
Хүүхэд хамгаалал	2,915	5.2%	1.8%
Хүүхдийн эрхийн зөрчил	1,192	2.1%	0.7%
Зөвлөгөө хүссэн	12,968	23.2%	8.1%
Мэдээлэл хүссэн	25,623	45.8%	16.1%
Чимээгүй	12,973	23.2%	8.1%
Гомдол , санал	218	0.4%	0.1%
Зорилтот бус дуудлага	103,691		65%
Нийт	159,580		100%

Эх сурвалж: Тусламжийн утас 108

Нийт дуудлагын 40 орчим хувь нь Улаанбаатар хотоос, 98.4 хувь нь гар утаснаас хийгддэг байна. 2015 онд Тусламжийн утсаар хүлээн авсан дуудлагад үндэслэн 2 596 кэйс нээгдсэн бөгөөд үүний тал орчим хувь нь оны эцэс гэхэд хаагдсан байна. Тусламжийн утсаар сард дунджаар 242 хүүхэд хамгаалалтай холбогдсон дуудлага ирдэг байна.

Хүснэгт Хүснэгт 5-д Тусламжийн утсаар 2014, 2015 онуудад ирсэн хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлагын тоог дуудлагын төрлөөр ангилж үзүүлэв. Нийт дуудлагын хамгийн өндөр хувийг бие махбодын хүчирхийлэлтэй холбоотой дуудлага эзэлж байгаа бол түүний дараа хүүхдээ үл хайхрахтай холбоотой дуудлага орж байна.

Хүснэгт 5: Тусламжийн утас 108-д ирсэн хүүхэд хамгаалалтай холбоотой дуудлагууд

	2014		2015	
	6-12 сард ирсэн дуудлага	Нийт дүнд эзлэх %	1-12 сард ирсэн дуудлага	Нийт дүнд эзлэх %
Алга болсон	17	1.7%	97	3.3%
Амиа хорлох	24	2.4%	29	1.0%
Барьцаалсан	2	0.2%	2	0.1%
Бие махбодын хүчирхийлэл	252	24.7%	1078	37.0%
Бэлгийн хүчирхийлэл	46	4.5%	132	4.5%
Ганцаардсан	39	3.8%	25	0.9%
Гуйлга гуйлгасан	37	3.6%	135	4.6%
Гутралд орсон	22	2.2%	10	0.3%
Гэмт хэрэгт ашигласан	11	1.1%	13	0.4%
Гэрч	5	0.5%	1	0.0%
Гэрээсээ дайжсан	30	2.9%	26	0.9%

ДОХ		0.0%	4	0.1%
Мөлжлөг	14	1.4%	0	0.0%
Нас барсан		0.0%	78	2.7%
Сэтгэл санааны дарамт	176	17.3%	173	5.9%
Төөрсөн	8	0.8%	35	1.2%
Тэвчишгүй хөдөлмөр эрхэлдэг	26	2.5%	46	1.6%
Үл хайхарсан	162	15.9%	376	12.9%
Хараа хяналтгүй	62	6.1%	134	4.6%
Хүний наймаа	0	0.0%	0	0.0%
Цахим дарамт	4	0.4%	58	2.0%
Яаралтай	33	3.2%	372	12.8%
Бусад	50	4.9%	91	3.1%
Нийт	1020	100.0%	2915	100.0%

Эх сурвалж: Тусламжийн утас 108

1.1.5 Улаанбаатар хотыг ХГБХ-ийн Газар

Нийслэлийн хүүхдийн төлөө газрыг 2013 онд Нийслэлийн ХХГБХ-ийн газар болгон шинэчлэн зохион байгуулсан. Тус газар нь нийт 4 хэлтэст 32 ажилтны орон тоотойгоос Гэр бүл хүүхэд хамгааллын хэлтэст 7 ажилтан, Гэр бүл, хүүхдийн хөгжлийн хэлтэст 8 ажилтны орон тоотой. Газрын даргыг ХТҮГ-ын даргатай зөвшилцөж, нийслэлийн Засаг дарга томилдог.

Нийслэлийн ХГБХ-ийн газар нь 2013 онд нийслэлийн 9 дүүрэгт шинээр бий болсон ХГБХ-ийн төвүүдийг удирдлагаар хангадаг. Улаанбаатар хотын ХГБХБ-ын төсөв, орон тоог Хүснэгт Хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 6: Улаанбаатар хотын ХГБХБ-ын төсөв

	2015 оны төсөв /сая төгрөгөөр/	Орон тоо, 2015 онд
Нийслэлийн ХГБХ-ийн газар	288.4	32
Дүүргүүдийн ХГБХ-ийн төв	1,311.0	123
Чингэлтэй	151.0	22
Сонгинохайрхан	167.8	14
Сүхбаатар	123.2	15
Баянгол	143.5	11
Баянзүрх	149.6	15
Хан-Уул	192.3	9
Налайх	127.0	13
Багануур	154.7	13
Багахангай	102.0	11
Нийт	1,599.4	155

Эх сурвалж: Нийслэлийн ХГБХ-ийн газар

Нийт 1.36 сая хүн амтай Улаанбаатар хотод 8 874 хүн тутамд нэг ХГБХ-ийн байгууллагын ажилтан (гэрээт болон туслах ажилчдыг оролцуулан) ногдож байна.

1.1.6 Аймгуудын ХГБХ-ийн хэлтэс

Аймгуудын Хүүхдийн хэлтсийг 2012 онд ХГБХ-ийн хэлтэс болгон өөрчилсөн. Дундаж ХГБХ-ийн хэлтэс 200 сая төгрөгийн жилийн төсөвтэй, 14 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Аймгуудын ХГБХ-ийн хэлтсийн 2015 оны төсөв болон орон тоог Хүснэгт Хүснэгт 7-д үзүүлэв. Аймгууд дунджаар 78 мянган хүн амтай бөгөөд ХГБХ-ийн хэлтсийн нэг ажилтан тутамд 6100 хүн ногдож байна. Хэдийгээр Улаанбаатар хоттой харьцуулахад хүн амын тоо бага боловч аймгуудад хүн амын нягтаршил бага, дэд бүтцийн хөгжил сул нь ХГБХ-ийн үйлчилгээг хүргэхэд бэрхшээл учруулдаг. Аймгийн нийт хүн амын дунджаар 30 орчим хувь нь аймгийн төвд, үлдсэн хэсэг нь аймгийн төвөөсөө дунджаар 130 км-т орших сумдад оршин суудаг. Нэг аймагт нийт 13⁴ - 24 сум, дунджаар 18 сум байдаг. Ихэнх аймгийн ХГБХ-ийн хэлтэс хүүхэд гэр бүлтэй холбоотой яаралтай арга хэмжээ шаардсан асуудлуудад гадар дээр нь ажиллаж түргэн шуурхай хариу өгөхөд шаардлагатай тээврийн хэрэгсэл байдаггүй.

Хүснэгт 7: Аймгуудын ХГБХ-ийн хэлтсүүдийн 2015 оны төсөв, орон тоо

	2015 budget /MNT, millions/	Орон тоо	Аймгийн хүн ам	ХГБХБ-ын нэг ажилтанд ногдох хүн ам
Архангай	172.9	13	93,086	7,160
Баян-Өлгий	114.9	8	95,151	11,894
Баянхонгор	129.9	12	83,044	6,920
Булган	126.7	8	60,494	7,562
Говь сүмбэр	76.1	5	16,058	3,212
Говь-Алтай	389.2	21	56,735	2,702
Дархан-уул	224.5	22	99,947	4,543
Дорноговь	168.2	19	63,808	3,358
Дорнод	201.2	18	75,194	4,177
Дундговь	263.7	22	44,351	2,016
Өвөрхангай	164.3	10	112,992	11,299
Өмнөговь	128.4	6	59,694	9,949
Завхан	158.3	11	69,732	6,339
Орхон	240.9	21	94,421	4,496
Сүхбаатар	159.2	16	57,423	3,589
Сэлэнгэ	313.6	27	106,212	3,934
Төв	288.2	11	90,107	8,192
Увс	128.8	8	75,792	9,474
Хөвсгөл	270.4	16	126,043	7,878
Ховд	326.6	18	81,479	4,527
Хэнтий	153.9	11	71,212	6,474
Нийт	4199.8	303.0	1,632,975	5,389

Эх сурвалж: СЯ, ҮСГ

Аймгуудын болон, Улаанбаатар хотын ХГБХ-ийн хэлтэс нь хүүхэд хамгаалалд зайлшгүй шаардлагатай газар дээр нь ажиллах үйл ажиллагаанд зарцуулах төсөв байдаггүй. Төсвийн дунджаар 70% нь ажиллагсдын цалин болон, НД, ЭМД-ын

⁴ Нийт 2-4 сумтай Орхон, Дархан-Уул, Говь-Сүмбэр аймгуудыг оролцуулаагүй.

шимтгэл, нэг удаа олгох буцалтгүй тусламж зэрэг ажиллагсдад төлөх төлбөрт зориулагддаг. Энэ төрлийн зардлын дүнг Хүснэгт 8-д ажиллагсдын зардал баганад харуулсан.

Хүснэгт 8: ХГБХ-ийн байгууллагуудын ажиллагсдын болон бусад гол урсгал зардлууд, 2015 онд, сая төгрөгөөр

	Нийт зардал	Ажиллагсдын зардал	Гол урсгал зардлууд	Ажиллагсдын болон гол урсгал зардлын нийт зардалд эзлэх %
Архангай	172.9	125.3	40.1	96%
Баян-Өлгий	114.9	93.5	17.7	97%
Баянхонгор	129.9	108.9	15.8	96%
Булган	126.7	84.1	34.0	93%
Говь сүмбэр	76.1	61.6	10.6	95%
Говь-Алтай	389.2	178.2	197.2	96%
Дархан-уул	224.5	193.8	24.6	97%
Дорноговь	168.2	122.5	36.7	95%
Дорнод	201.2	171.4	18.6	94%
Дундговь	263.7	166.3	81.7	94%
Өвөрхангай	164.3	111.3	39.6	92%
Өмнөговь	128.4	87.7	13.2	79%
Завхан	158.3	95.9	54.0	95%
Орхон	240.9	209.8	23.4	97%
Сүхбаатар	159.2	119.9	28.9	93%
Сэлэнгэ	313.6	206.0	91.0	95%
Төв	288.2	92.7	185.3	96%
Увс	128.8	111.7	14.8	98%
Хөвсгөл	270.4	133.8	129.6	97%
Ховд	326.6	181.4	139.8	98%
Хэнтий	153.9	84.8	63.3	96%
Улаанбаатар	288.4	262.2	6.4	93%
Нийт	4,488.3	3,002.9	1,266.3	95%
Дундаж	204.0	136.5	57.6	95%

Эх сурвалж: СЯ

Хүснэгт 8 –д “гол урсгал зардлууд” баганад үзүүлсэн тог цахилгаан, халаалт, цэвэр бохир ус, бичиг хэрэг, хэвлэл, харилцаа холбооны зардлууд нийт төсвийн 25 хувийг эзэлж байна.

Эдгээр нь зөвхөн ХГБХ-ийн байгууллагууд төдийгүй бусад ямар ч байгууллага үйл ажиллагаагаа явуулахын тулд тогтмол төлөх ёстой, хүүхэд, гэр бүлийн үйлчилгээтэй шууд холбоогүй зардлууд юм. Хүснэгт Хүснэгт 9-д үзүүлсэнчлэн Монгол улсын байгаль, цаг уурын нөхцөлөөс шалтгаалан халаалтын зардал нь бусад урсгал зардлууд дотроо хамгийн өндөр дүнтэй бөгөөд нийт зардлын 22 хувь, гол урсгал зардлуудын 75 хувийг тус тус эзэлж байна.

Ажиллагсдын зардал болон, гол урсгал зардлуудад нийт төсвийн 95% зарцуулагдсанаар сургалт, зөвлөгөө, газар дээр нь ажиллах зэрэг үйл ажиллагаанд зарцуулах төсөв бараг үлддэггүй байна.

Хүснэгт 9: ХГБХ-ийн байгууллагуудын гол урсгал зардлууд, 2015 оны төсөв, сая төгрөгөөр

	Бичиг хэрэг	Тог цахилгаан	Ном хэвлэл	Халаалт	Цэвэр, бохир ус	Шуудан, Холбоо, Интернет	Нийт
Архангай	0.4	2.9	-	35.9	0.4	0.5	40.1
Баян-Өлгий	0.2	0.4	-	16.3	0.3	0.5	17.7
Баянхонгор	0.5	0.8	-	9.1	4.8	0.7	15.8
Булган	0.7	1.6	-	27.9	1.8	2.0	34.0
Говь сүмбэр	0.5	0.4	-	8.4	-	1.3	10.6
Говь-Алтай	2.0	16.4	-	164.0	13.1	1.7	197.2
Дархан-уул	0.2	4.1	-	17.4	2.7	0.2	24.6
Дорноговь	0.4	8.4	0.1	25.1	1.8	0.9	36.7
Дорнод	0.6	2.2	0.1	12.5	1.8	1.4	18.6
Дундговь	0.4	17.7	0.1	50.2	12.7	0.6	81.7
Өвөрхангай	0.8	2.4	0.1	33.9	1.4	1.0	39.6
Өмнөговь	0.4	2.5	-	7.9	1.6	0.8	13.2
Завхан	0.8	1.8	-	49.5	1.0	1.0	54.0
Орхон	0.5	5.1	-	14.1	3.5	0.2	23.4
Сүхбаатар	0.5	1.2	-	25.3	1.4	0.5	28.9
Сэлэнгэ	1.4	8.6	0.2	72.2	7.2	1.4	91.0
Төв	0.5	5.4	0.1	175.8	2.9	0.7	185.3
Увс	0.2	0.5	-	12.7	0.8	0.5	14.8
Хөвсгөл	0.5	5.1	-	121.0	2.4	0.5	129.6
Ховд	0.5	2.5	0.1	133.6	2.6	0.5	139.8
Хэнтий	0.4	1.9	-	60.4	0.2	0.5	63.3
Улаанбаатар	2.0	-	0.4	-	-	4.0	6.4
Нийт	14.5	91.8	1.0	1,073.3	64.2	21.5	1,266.3
Дундаж	0.7	4.2	0.0	48.8	2.9	1.0	57.6

Эх сурвалж: СЯ

Жишээлбэл дундаж ХГБХ-ийн хэлтэс тээвэр, түлш, дотоод томилолтын зардлын жилийн төсөв 2.64 сая төгрөг (~1.3 мянган ам. доллар) байна (Хүснэгт Хүснэгт 10). Энэ өчүүхэн хэмжээний зардал нь хүүхэд хамгааллын арга хэмжээнд бус захиргааны үйл ажиллагаанд зарцуулагдаад дуусдаг. Иймд ХГБХ-ийн байгууллагын ажилтнууд аймгийн төв дотор хүүхэд хамгаалалтай холбоотой ажлаар зорчих зэрэг жижиг зардлуудыг өөрийн халааснаас ихэвчлэн төлдөг. Харин аймгийн төвөөс сумдад явах шаардлага гарахад бусад байгууллагуудын тээврийн хэрэгслийг түр зээлдэх, эсвэл ажилтнууддаа албан томилолт бичилгүйгээр бусдын унаанд дайж явуулах зэргээр тухайн үед нь шийддэг байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчидтой ажиллахад хэрэг болдог боолт, ариун цэврийн цаас зэргийг ХГБХ-ийн байгууллагын ажилтнууд өөрснөө төлж авч өгөх явдал цөөнгүй тохиолддог. Төсвийн хүрэлцээгүй байдал нь ХГБХ-ийн байгууллагуудын хамгаалал шаардлагатай хүүхдэд туслах боломжийг бусад олон талаар хязгаарладаг. Жишээлбэл, өндөр эрсдэлтэй гэр бүлүүдэд тэр бүр очиж хяналт

тавьж чаддаггүй бөгөөд, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил бараг хийгддэггүй байна.

Хүснэгт 10: ХГБХ-ийн байгууллагуудын тээвэр, дотоод томилолтын зардал, 2015 оны төсөв, сая төгрөгөөр

	Тээвэр, түлш шатахуун	Дотоод томилолт	Нийт
Архангай	0.5	0.9	1.5
Баян-Өлгий	0.4	1.4	1.9
Баянхонгор	0.5	0.9	1.4
Булган	1.2	1.9	3.1
Говь сүмбэр	0.4	0.8	1.2
Говь-Алтай	2.6	4.4	6.9
Дархан-уул	0.9	0.8	1.7
Дорноговь	0.8	1.3	2.1
Дорнод	0.8	1.4	2.2
Дундговь	2.0	2.1	4.2
Өвөрхангай	3.1	2.4	5.5
Өмнөговь	1.3	1.1	2.3
Завхан	1.6	2.6	4.2
Орхон	0.5	0.3	0.8
Сүхбаатар	1.0	1.1	2.0
Сэлэнгэ	1.6	1.0	2.5
Төв	0.6	2.8	3.4
Увс	0.5	0.6	1.1
Хөвсгөл	1.0	2.3	3.3
Ховд	1.1	1.1	2.2
Хэнтий	0.4	0.2	0.6
Улаанбаатар	3.2	0.7	3.9
Нийт	25.9	32.1	58.0
Дундаж	1.2	1.5	2.6

Эх сурвалж: СЯ

Төсөв хүрэлцээгүйн улмаас ХГБХ-ийн байгууллагуудын үйл ажиллагаагаа Дэлхий Зөн зэрэг хандивлагч байгууллагууд, хувийн сектор болон Төрийн бусад байгууллагуудын тусламжид багагүй хэмжээгээр түшиглэдэг.

1.1.7 Сум, хорооны нийгмийн ажилтнууд

Улаанбаатар хот⁵ болон аймгийн төвүүдийн⁶ ихэнх хороодод хорооны нийгмийн ажилтан ажилладаг. Тэдний ажлын цагийн ихэнх нь иргэдийн нийгмийн хөтөлбөрүүдэд хамрагдах хүсэлтийг судлах зэрэг нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагддаг. Мөн бусад олон чиглэлийн үүрэг дээд шатны байгууллагуудаас албан болон албан бусаар өгөгддөгөөс нийгмийн

⁵ There are 152 khoroos in 9 districts of Ulaanbaatar city with average population of 8000 people per khoroos.

⁶ Provincial centers have one average 5-6 khoroos with average population of 2000 people per khoroos.

ажилтнуудад хүүхэд хамгааллын асуудалд анхаарал хандуулах цаг зав тэр бүр гардаггүй байна.

Сумын түвшинд хүүхэд, гэр бүлийн асуудлыг сумын Засаг даргын тамгын газрын ажилтан хариуцдаг. Энэ албан тушаал сумдад нийгмийн бодлогын мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хүүхэд залуучуудын асуудал хариуцан мэргэжилтэн зэргээр өөр өөрөөр нэрлэгддэг. Энэ орон тоонд сум бүрд нэг хүн ажилладаг гэж тооцвол, улсын хэмжээнд нийт 330 хүн сумын түвшинд хүүхэд, гэр бүлийн асуудлыг хариуцаж байна.

1.1.8 Сургуулийн нийгмийн ажилтан

Боловсрол,Соёл, Шинжлэх ухааны Яамнаас гаргасан статистикаар улсын хэмжээнд 760 сургуулийн нийгмийн ажилтан дунд болон Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд ажиллаж байна. Хэдийгээр сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолтод хүүхэд хамгаалах, зөвлөгөө өгөх үүрэг багтаг боловч тэдний ажлын ихэнх цаг нь сургуулийн сахилга батыг хангах, уралдаан тэмцээн зохиоход зарцуулагддаг.

1.1.9 Нийслэлийн цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэс

Энэ хэлтэс нь 2014 оны 2 сард үүсгэн байгуулагдаж одоогоор 7 цагдаагийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

1.2 Асрамжийн газрууд

1.2.1 Өнөр бүл төв

ХТҮГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулдаг Өнөр бүл төв нь Монгол улсад гэр бүлийн орчин дутагдсан хүүхдүүдэд байнгын асрамж халамжийн үйлчилгээ хүргэдэг гол байгууллага юм. Тус төв нь 2015 онд 2 тэрбум төгрөгийн төсөвтэй, 0-18 насны 240 хүүхэдтэй үйл ажиллагаагаа явуулсан.

Хүснэгт Хүснэгт 11-д үзүүлснээр тус төвийн үйл ажиллагааны зардлын ихэнх хэсэг буюу 60 хувийг ажиллагсдын зардал эзэлдэг бөгөөд түүний дараах хамгийн том зардал нь хүүхдүүдийн хоолны зардал байна. Өнөр бүл төвийн нэг хүүхэдэд ногдох жилийн дундаж зардал 8.6 сая болж байна. .

Хүснэгт 11: Өнөр бүл төвийн 2015 оны төсөв

Зардлын төрлүүд	Дүн, сая төгрөгөөр	Нийт дүнд эзлэх %
Цалин, НДШ, ЭМДШ	1,226	59%
Бараа үйлчилгээний зардал	828	40%
Халаалт	51	2%
Тог, цахилгаан	49	2%
Цэвэр, бохир ус	49	2%
Бичиг хэрэг	10	0%

Тээвэр, шатахуун	22	1%
Шуудан, харилцаа холбоо, интернет	5	0%
Хувцас, зөөлөн эдлэл	140	7%
Хоол	425	20%
Бусад	76	4%
Тусламж, шилжүүлэг	19	1%
Нийт	2,073	100%

Эх сурвалж: СЯ

1.2.2 Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор

Нийслэлийн засаг захиргааны харьяанд ажилладаг энэхүү цогцолбор нь 4-18 насны 100 орчим хүүхдэд байнгын асрамж үзүүлдэг бөгөөд дүүргийн засаг даргын захирамжаар болон УБ хотын цагдаагийн газрын түр хамгаалах байрнаас шилжин ирсэн хүүхдүүдийг хүлээн авдаг.

Тус цогцолбор нь анх 1991 онд Итгэл төв нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн боловч 2013 оны 3 сард одоогийн хэлбэрээрээ шинэчлэн зохион байгуулагдсан. 2015 онд жилийн 1.26 тэрбум төгрөгийн төсөвтэй, 68 ажилтантай үйл ажиллагаагаа явуулсан. Энэ цогцолборт хүмүүжиж буй нэг хүүхдэд ногдох жилийн зардал нь 7 сая төгрөг болж байна.

1.2.3 Хүүхдийн сувилал

Улаанбаатар хотод байрлах хүүхдийн сувилал нь 0-3 насны өнчин хүүхдүүд болон эрүүл мэндийн хувьд асаргаа сувилгаа шаардлагатай (хүнс тэжээлийн дутагдалтай, тахир дутуу, өсөлтийн хоцролтой г.м) хүүхдүүдийг аймаг, нийслэл, дүүргийн засаг даргын шийдвэр, шүүх, цагдаагийн газар болон хүүхдийн эмнэлгүүдийн тодорхойлолтод үндэслэн хүлээн авч сувилдаг. Анх 1966 онд байгуулагдсан бөгөөд 2012 оноос эхлэн одоогийн зохион байгуулалтаараа ажиллаж байна. Нийт 118 ажилтантай, нэг удаа 90 хүүхэд хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай. Сувилал нь Эрүүл мэнд, Спортын яаманд харьяалагддаг бөгөөд 2015 онд тус яамны сайдын багцад хуваарилагдсан 1.63 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулсан.

1.2.4 Энэрэл төв

Эрдэнэт хотод байрлах Энэрэл төв нь 21 ажилтантай 5-18 насны 40 хүүхдэд асрамжийн үйлчилгээ үзүүлдэг. Тус төв нь 1993 оноос хойш Эрдэнэт үйлдвэрээс санхүүжиж байгаа бөгөөд төсөв санхүүгийн мэдээллийг олох боломжгүй байв.

1.2.5 ТББ, хувийн санхүүжилттэй бусад асрах төвүүд

ХТҮГ-аас гаргасан тайлангаас үзэхэд 2014 оны байдлаар ТББ болон хувийн санхүүжилттэй 32 хүүхэд асрах төвүүдэд нийт 675 хүүхэд өсөж хүмүүжиж байна. Нэг төв нь дунджаар 21 хүүхэдтэй. Эдгээрийн нэгээс бусад нь Улаанбаатар хотод байрладаг.

1.3 Түр хамгаалах байрууд

1.3.1 Нийслэлийн цагдаагийн газрын дэргэдэх түр хамгаалах байр

Хуучнаар хүүхдийн хаяг тогтоох төвийг 2014 оны 4 сард нэг дор 30 хүн 30 хүртэл хоногоор хүлээн авах боломжтой Түр хамгаалах байр болгон өөрчилсөн.

Энэ байранд 2015 онд 500 гаруй хүн ирснээс 67% нь хүүхэд, 33 хувь нь насанд хүрсэн эмэгтэйчүүд байна. Асран хамгаалах хүнгүй хүүхдүүдийг эндээс Өнөр Бүл төв болон, Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт шилжүүлдэг. Төв нь жилийн 251 сая төгрөгийн төсөвтэй_ 23 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

1.3.2 Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн дэргэдэх хамгаалах байр

Нийгмийн халамжийн тухай хуулиар түр байршуулан асрамжлах үйлчилгээ нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэг төрөл бөгөөд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн дэргэдэх хамгаалах байр нь энэ үйлчилгээг гэрээгээр хүргэдэг. Улаанбаатар хотод байрлах хамгаалах байр нь нэг дор 20 хүнийг хүлээн авах хүчин чадалтай. Сүүлийн 5 жилийн статистикаас үзэхэд жилд дунджаар 180 хүнийг хүлээн авч дунджаар 30 хоног байршуулдаг байна. Иргэд 7 хоногоос 3-4 сарын хугацаанд байрлах боломжтой. Хамгаалах байранд НХҮЕГ-аас нэг хүнд хоногийн 14,950 төгрөгөөр тооцож санхүүжилт олгодог.

1.3.3 Аймгийн төвүүд дэх хамгаалах байр

Цөөн хэдэн аймгийн төвд ихэвчлэн ТББ-с санхүүжилттэй хамгаалах байрууд ажилладаг. Хамгийн сүүлд Өвөрхангай аймгийн төвд хамгаалах байр Австралийн Засгийн газрын санхүүжилт, орон нутгийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв Сэлэнгэ, Төв аймгуудад хамгаалах байр байгуулсан боловч эдгээр санхүүжилт дутагдалтайн улмаас байнга үйл ажиллагаа явуулдаггүй.

1.4 Хүүхдийн халамж, хамгаалалд зориулж буй Засгийн Газрын бусад зардлууд

1.4.1 Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу олгогддог тэтгэмжүүд

Нийгмийн халамжийн тухай хууль (“НХТХ”)-ийн дагуу дараах тэтгэмж, тусламжийг гэр бүл, хүүхдүүдэд олгож байна:

- Хуулийн 12.1.4-р зүйлийн дагуу тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдэд тухайн гэр бүл дэх хүүхдийн тооноос хамаарч нэг хүүхдэд сард 126,500-230,000 төгрөгийн халамжийн тэтгэвэр олгодог;
- Хуулийн 12.1.5-р зүйлийн дагуу, 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэгт сард нэг хүүхдэд 126,500 төгрөгийн халамжийн тэтгэвэр олгодог;

- Хуулийн 13.2.1-р зүйлийн дагуу бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн сард 58,000 төгрөгийн тэтгэмж авдаг;
- Хуулийн 13.2.2-р зүйлийн дагуу Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн сард 58,000 төгрөгийн тэтгэмж авдаг;
- Хуулийн 13.2.4-р зүйлийн дагуу эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэн сард 58,000 төгрөгийн тэтгэмж авдаг;
- Хуулийн 13.5.5-р зүйлийн дагуу хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэн хүүхэд тус бүрд 1 сая төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламжаар авах боломжтой. 3 ихэр хүүхдийн хувьд буцалтгүй тусламжийн хэмжээ 3 сая төгрөг болж нэмэгддэг;
- Хуулийн 13.5.6-р зүйлийн дагуу байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд сард 126,500 төгрөгийн буцалтгүй тусламж олгогддог;
- Хуулийн 13.5.8-р зүйлийн дагуу гурав ба түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-д жилд 120,100 төгрөгийн тэтгэмж олгогддог;
- Хуулийн 13.7-р зүйлийн дагуу Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 40,000 төгрөгийг жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар бүр олгодог.

Хүснэгт 12: Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу олгогддог нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжүүд

НХТХ-ийн зүйл заалт	2013		2014	
	Хамрагдсан хүний тоо	Дүн, сая төгрөгөөр	Хамрагдсан хүний тоо	Дүн, сая төгрөгөөр
12.1.4	14,125	18,124	14,971	19,793
12.1.5	-	-	45	48
13.2.1	2,293	1,317	2,381	1,524
13.3.2	9	6	12	7
13.2.4	7,339	3,800	7,559	4,341
13.3.5	3,996	6,899	1,025	2,001
13.5.5	36	281	15	129
13.5.6	5,436	3,123	5,912	3,540
13.5.8	1,836	200	1,538	184
13.7	969,378	38,327	970,431	38,326
Total	1,004,448	72,078	1,003,889	69,892

Эх сурвалж: НХҮЕГ

Хүснэгт Хүснэгт 12-д НХТХ-ийн дагуу олгогддог тэтгэвэр, тэтгэмжийн нийт дүн болон хүлээн авсан иргэдийн тоог харуулав.

1.4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогддог тэтгэмж, тусламж

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль (“ХБИНХТХ”)-ийн дагуу дараах тэтгэмж, тусламжийг олгодог:

- Хуулийн 5.1.2-р зүйлийн дагуу 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр (2 жил тутамд 1 удаа) 100 хувь нөхөн олгодог;
- Хуулийн 5.1.5-р зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа 200,000 төгрөгөөр хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчилдэг;
- Хуулийн 5.1.8-р зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлдэг
- Хуулийн 5.1.13-р зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгодог;

Хүснэгт Хүснэгт 13-д ХБИНХТХ-ийн дагуу олгогддог тусламж, тэтгэмжийн дүн болон хүлээн авсан иргэдийн тоог харуулав.

Хүснэгт 13: ХБИНХТХ-ийн дагуу олгогддог тусламж, тэтгэмжүүд

ХБИНХТХ-ийн зүйл заалт	2013		2014	
	Хамрагдсан хүний тоо	Дүн, сая төгрөгөөр	Хамрагдсан хүний тоо	Дүн, сая төгрөгөөр
5.1.2	1,788	893	2,890	1,116
5.1.5	172	34	150	29
5.1.8	6	2	1	2
5.1.13	24	13	159	8
Total	1990	942	3200	1155

Эх сурвалж: НХҮЕГ

1.4.3 Хүүхдийн мөнгө

Засгийн Газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийн дагуу Хүүхдийн мөнгө хөтөлбөрөөр сар тутам 0-18 насны хүүхэд бүрд 20,000 төгрөгийг олгож эхэлсэн. 2015 онд нийт хүүхдийн 6% нь хүүхдийн мөнгө авах хүсэлтээ гаргаагүй бөгөөд 94% нь мөнгө олгогдсон байна.

Хүснэгт 14: Хүүхдийн мөнгөний олголт

	# авсан хүүхдийн тоо	Дүн, тэрбум төгрөгөөр
2012	896,209	53.26
2013	948,616	208.30
2014	994,159	238.43
2015	1,027,608	246.62
Нийт		746.61

Эх сурвалж: НХҮЕГ

Хэдийгээр хүүхдийн мөнгө нь хүүхэд хамгаалалд зориулагдан тусгайлан олгогдож буй мөнгө биш боловч, орлого багатай иргэдийн хувьд орлогын багагүй эх үүсвэр болж хүүхдийн аж байдлыг дэмжихэд чухал нөлөө үзүүлдэг.

1.5 Засгийн Газраас хүүхэд хамгаалалд зориулж буй зардлын нэгтгэл

Энэ хэсэгт өнөөг хүртэл хэлэлцсэн зүйлсийг нэгтгэн хүүхэд хамгаалалтай холбоотой зардлууд энэ салбарын хүний нөөцийн талаарх ерөнхий дүр зургийг гаргав. Хүснэгт Хүснэгт 15-д Засгийн газраас 2015 онд хүүхэд чиглэсэн арга хэмжээ, хөтөлбөрийн зардал энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудын төсөв болон хүний нөөцийн байдлыг харуулсан. Хүснэгтэд мөн хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан цагдаагийн албан хаагч зэрэг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагад харьяалагддаггүй боловч хүүхэд хамгааллын асуудалд оролцоотой төрийн байгууллагын ажилтнууд, тэдний цалин (тооцоолсноор), хүүхдийн мөнгө, НХТХ, ХБИНХТХ-ийн дагуу олгогддог тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг оруулсан. Харин эмч, эмнэлгийн ажилтнууд, шүүх, сургуулийн нийгмийн ажилтнууд болон төрийн бусад албан хаагчдын хүүхэдтэй холбоотой асуудалд зарцуулсан цаг хугацаа болон материал, үйлчилгээний зардлыг оруулаагүй.

Хүснэгт Хүснэгт 15-д үзүүлснээр улсын хэмжээнд нийт 1 295 төрийн албан хаагч хүүхэд, гэр бүлийн холбогдолтой асуудал хариуцан ажиллаж байна. 2015 онд Төрөөс хүүхэд гэр бүлийн асуудалд нийт 332 тэрбум төгрөг зарцуулсны 95 хувийг Хүүхдийн мөнгө, НХТХ, ХБИНХТХ-ийн дагуу олгогддог тэтгэвэр, тэтгэмж, тусламж эзэлж байгаагаас 74% нь Хүүхдийн мөнгөтэй холбоотой байна.

Хүснэгт Хүснэгт 15-д үзүүлсэн зардлын ихэнх хэсэг нь хүүхэд хамгаалалд зарцуулагддаггүй. Жишээлбэл, Хүүхдийн мөнгө нь хамгаалал шаардлагатай эсэхээс үл хамааран бүх хүүхдүүдэд олгогддог бол НХТХ, ХБИНХТХ-ийн дагуу олгогддог тэтгэвэр, тэтгэмж, тусламж нь тухайн хүүхэд хамгаалал шаардлагатай эсэхэд бус хүүхэд, гэр бүлийн санхүүгийн хэрэгцээ, шаардлагад үндэслэн олгогддог. Иймд зөвхөн хүүхэд хамгаалалд тусгайлан зарцуулагдаж буй санхүү, хүний нөөцийг тодорхойлохын тулд Хүснэгт Хүснэгт 15-д үзүүлсэн дүнд зарим тохируулга хийх шаардлагатай.

Хүснэгт 15: Засгийн газраас зарцуулж буй хүүхэдтэй холбоотой зардлууд

	2015 оны зардал (сая төг)	Орон тоо
ХГБХ-ийн үндсэн бүтэц дэх байгууллагууд	7,372	477
ХТҮГ	1,722	34
Улаанбаатар хотын ХГБХ-ийн газар	288	32
Улаанбаатар хотын дүүргүүдийн ХГБХ-ийн төвүүд	1,162	108
Аймгуудын ХГБХ-ийн хэлтэс	4,200	303
ХГБХ-ийн үндсэн бүтцээс гаднах ажилтнууд	3,440⁷	587
Сум, хорооны нийгмийн ажилтан	3,265	557
Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэг хариуцсан цагдаагийн ажилтнууд	176	30
Хамгаалах байрууд	3,618	231
Асрамжийн газрууд	3,286	204
Өнөр бүл төв	2,026	136
Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор	1,260	68
Түр хамгаалах байрууд	332	27
Нийслэлийн цагдаагийн газрын түр хамгаалах байр	251	23
Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн түр хамгаалах байр	81	4
НХТХ, ХБИНХТХ-ийн дагуу олгогдох тэтгэмжүүд	71,047	
Хүүхдийн мөнгө	246,625	
Нийт	332,102	1,295

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Гэвч ХГБХ-ийн байгууллагуудын хүүхэд хамгаалал, хүүхэд гэр бүлийн хөгжил, хүүхдийн хөгжил оролцоо, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг харилцан уялдаатай асуудлуудад зарцуулж буй санхүүгийн болон хүний нөөцийг ялгаж харуулах нь амаргүй юм. Энэ нь эдгээр үйл ажиллагааг бүгд ХГБХ-ийн нэг байгууллага хариуцдаг бөгөөд энэ байгууллагууд гаргасан зардал, хүний нөөцийн хуваарилалтаа үйл ажиллагааны чиглэл тус бүрээр салгаж гаргадаггүйтэй холбоотой. Хүснэгт Хүснэгт 15-д харуулсан зардлууд дотроос зөвхөн хүүхэд хамгаалалд тусгайлан зарцуулагдсан гэж тооцоолсон зардлуудыг Хүснэгт Хүснэгт 16-д харуулав.

Хүснэгт Хүснэгт 16-д харуулсан зардлуудыг ХТҮГ-ийн үйл ажиллагааны 60%, Улаанбаатар хот, аймаг дүүргүүдийн ХГБХ-ийн байгууллагуудын үйл ажиллагааны 80% нь хүүхэд хамгаалалтай холбоотой зардал гэсэн төсөөлөлд үндэслэн гаргасан. Эдгээр хувиудыг гаргахдаа дээрх байгууллагуудын нийт ажилтнууд дотор хүүхэд хамгааллын асуудал хариуцсан ажилтнуудын эзлэх хувийг харгалзан үзсэн. Мөн холбогдох хүмүүстэй хийсэн ярилцлагад үндэслэн нийгмийн ажилтнуудын ажлын цагийн 16%, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэг хариуцсан цагдаагийн

⁷ Тооцоолсноор

албан хаагчдын ажлын цагийн 70% нь хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлуудад зарцуулагддаг гэж тооцсон.

Хүснэгт 16: Хүүхэд хамгаалалд зарцуулагдаж буй санхүү, хүний нөөц

	2015 оны зардал (сая төг)	Орон тоо
ХГБХ-ийн үндсэн бүтэц дэх байгууллагууд	5,263	347
ХТҮГ	1,033	20
Улаанбаатар хотын ХГБХ-ийн газар	173	19
Улаанбаатар хотын дүүргүүдийн ХГБХ-ийн төвүүд	697	65
Аймгуудын ХГБХ-ийн хэлтэс	3,360	242
ХГБХ-ийн үндсэн бүтцээс гаднах ажилтнууд	645	110
Сум, хорооны нийгмийн ажилтан	522	89
Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэг хариуцсан цагдаагийн ажилтнууд	123	21
Хамгаалах байрууд	3,131	202
Асрамжийн газрууд	2,908	184
Өнөр бүл төв	2,026	136
Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор	882	48
Түр хамгаалах байрууд	222	18
Нийслэлийн цагдаагийн газрын түр хамгаалах байр	168	15
Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн түр хамгаалах байр	54	3
НХТХ, ХБИНХТХ-ийн дагуу олгогдох тэтгэмжүүд	-	-
Хүүхдийн мөнгө	-	-
Нийт	9,039	659

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Тооцооллоос үзэхэд хүүхэд хамгааллын чиглэлээр 659 төрийн албан хаагч ажиллаж улсын төсвөөс 9 тэрбум төгрөг зарцуулагдаж байна. Энэ нь Хүснэгт 15-д үзүүлсэн нийт зардлын зөвхөн 2.7% юм. Хүснэгт 16-д үзүүлсэн нийт зардлын 58% нь ХГБХ-ийн үндсэн бүтэц дэх байгууллагуудад, 35% нь асрамжийн газар болон түр хамгаалах байруудад, 7% нь ХГБХ-ийн үндсэн бүтцээс гадна боловч хүүхэд хамгаалалд шууд оролцоотой цагдаагийн албан хаагч болон сум хорооны нийгмийн ажилтнуудад ногдож байна. Хүүхэд хамгаалалд зарцуулагдаж буй 9.0 тэрбум төгрөг нь 2015 оны Засгийн газрын нийт зардал болох 7.13 их наяд төгрөгийн 0.13 хувьтай тэнцүү байна.

ХЭСЭГ 2: ХҮҮХЭД ХАМГААЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

2.1 Оршил

ХХТХ-ийн төслийн эхний хувилбар 2015 оны 5 сарын 11-д УИХ-д өргөн баригдсан боловч зардлын тооцооллын ажил эхэлснээс хойш 3 сарын дараа буюу 2015 оны 12-р сарын эхэнд төслийн баг хуулийн төслийн хоёрдугаар хувилбарыг хүлээн авсан. Энэхүү хоёрдугаар хувилбарт хуулийн төслийн талаар орон даяар явуулсан Ногоон Карг аяны хүрээнд хүлээн авсан саналуудыг тусгаж, эхний эхний хувилбарт байсан хуулийн зүйл заалтуудын ойролцоогоор гуравны хоёрт өөрчлөлт хийгдсэн. Зардлын тооцоолол нь төслийн хоёрдугаар хувилбарыг баримтлан хийгдсэн болно. ХХТХ нь УИХ-аар 2016 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан бөгөөд УИХ-аар батлагдсан хувилбар болон төслийн хоёрдугаар хувилбарын хооронд зарим ялгаа бий. Гэвч зардлын тооцоолол нь УИХ-аар батлагдсан хувилбарт орсон хүүхэд хамгааллын гол үйлчилгээнүүдийг хамарсан тул батлагдсан хувилбар болон төслийн хоёрдугаар хувилбарын хоорондын ялгаа нь зардлын тооцоололд сөрөг нөлөө үзүүлэхгүй. УИХ дээрх хэлэлцүүлгийн явцад төслийн багаас Төслийн баг УИХ дээрх хэлэлцүүлгийн явцад мэдээллээр хангах зорилгоор зардлын тооцооллын урьдчилсан дүнг хуулийн ажлын хэсэгт танилцуулж байсан.

ХХТХ-ийн зэрэгцээ УИХ-аар Хүүхдийн эрхийн тухай хууль⁸ болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Гэр бүлийн тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байна. Эдгээр хуулиуд нь ХХТХ-тай нягт уялдаатай бөгөөд ХХТХ-ийн дагуу хийгдэх хүүхэд хамгааллын ажлыг хийж гүйцэтгэх байгууллагын бүтэц, санхүү болон хүний нөөцтэй холбоотой чухал асуудлууд Гэр бүлийн тухай хууль болон, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудаар зохицуулагдаж байна. Иймд эдгээр дөрвөн хуулийг хамарсан нэгдсэн зардлын тооцооллыг хийх нь ач холбогдолтой байж болох юм. Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын хүрээ нь ХХТХ-аар хязгаарлагдаж буй тул Төрөөс үзүүлэх хүүхэд хамгаалалтай холбоотой зарим чухал үйлчилгээ зардлын тооцоололд хамрагдаагүй болно. Энэ талаар тодруулбал:

1. **Түр хамгаалах байр:** Түр хамгаалах байр хангалтгүй нь ХГБХБ-уудаас хамгааллын үйлчилгээг зохих ёсоор явуулах боломжийг хязгаарладаг. Гэвч түр хамгаалах байруудыг бий болгох асуудал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулагдахаар туссан. Иймд түр хамгаалах байруудыг байгуулах, ажиллуулахтай холбоотой зардлууд энэхүү зардлын тооцоололд ороогүй бөгөөд зөвхөн хүүхдүүдийг шаардлагатай үед хамгаалах байрт хүргэх, буцаан авах зардлууд орсон.

⁸ Энэ хууль нь УИХ-аар 2016 оны 2 дугаар сарын 6-д батлагдсан

2. **Орон нутаг дах ХГБХБ-ын хүний нөөц:** Зураг 1-д үзүүдсэнчлэн, сум, хорооны түвшинд ХГБХ-ийн асуудал тухайлан хариуцсан ажилтан одоогоор байгүй бөгөөд, энэ нь ХГБХБ-ын газар дээр хүрч үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарладаг. Орон нутагт ХГБХ-ийн асуудал хариуцсан ажилтнууд байх зайлшгүй шаардлагатай боловч ХГБХБ-ын бүтцийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулахаар тусгасан бөгөөд уг хуулийн одоогийн төсөлд ХГБХ-ийн байгууллага нь Зураг 2-д үзүүдсэн бүтэцтэй байхаар заасан байна. Хэдийгээр ХГБХ-ийн байгууллагыг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага тодорхой хэмжээгээр ХХТХ-аас үүдэлтэйгээр бий болж буй боловч ийнхүү өргөжүүлэх асуудал нь өөр хуулиар зохицуулагдаж буй тул зардлын тооцооллын хувилбаруудад ХГБХ байгууллагын орон тоог нэмэх асуудлыг гурван янзаар (орон тоо огт нэмэхгүй байх, бага хэмжээгээр нэмэх, бүрэн хэмжээгээр нэмэх) авч үзсэн.

Хэсэг 1-д ХГБХБ-уудын төсөв санхүү, хүний нөөцийн талаар дэлгэрэнгүй авч үзсэн тул энэ хэсэгт ХХТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвхөн одоо байгаа дээр нэмж шаардагдах төсөв санхүү, хүний нөөцийг авч үзсэн болно. ХХТХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт нь тухайн үеийн төсвийн боломж зэрэг олон хүчин зүйлсээс хамаарах тул зардлын тооцооллыг дараах 3 хувилбараар хийв:

- **Хувилбар 1 – “Дундын” хувилбар:** Энэ хувилбарт ХХТХ-ийн хэрэгжилттэй холбоотойгоор хүүхдийн хүчирхийллийн илрүүлэлт дундаж хэмжээгээр нэмэгдэж, ХГБХБ-ын материаллаг болон хүний нөөцийг зөвхөн аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд одоо байгаагаас нэмэгдүүлнэ гэж үзсэн. Төсөв санхүүгийн өнөөгийн нөхцөлд энэ хувилбар нь хэрэгжих хамгийн өндөр магадлалтай хувилбар юм. Цаашид төсөв санхүүгийн байдал сайжирсан үед энэ хувилбараар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өргөтгөж хүүхэд хамгааллын үйлчилгээг Хувилбар 2-д заасан түвшинд хүргэх боломжтой.
- **Хувилбар 2 – “Өсөлтийн” хувилбар:** Энэ хувилбарт ХХТХ-ийн хэрэгжилттэй холбоотойгоор хүүхдийн хүчирхийллийн илрүүлэлт дундаж хэмжээгээр нэмэгдэж, одоогоор хандивлагч байгууллагууд, иргэдээс санхүүжиж буй хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын тодорхой хэсгийг аажмаар улсын төсвөөс гаргадаг болох, мөн ХГБХБ-ын төсөв санхүү, хүний нөөцийг аймаг, нийслэл, дүүргийн төдийгүй сумын түвшинд өргөжүүлэх төсөөллийг ашигласан. Мөн зардлын загварт Хувилбар 1-ээс Хувилбар 2-т 5 жилийн хугацаанд аажмаар шилжих тохиолдолд жил тутмын зардал ямар байхыг тооцоолсон.
- **Хувилбар 3 – “Хэмнэлтийн” хувилбар:** Энэ хувилбарт хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хуулийн шаардлагыг дөнгөж хангах буюу боломжит хамгийн бага хэмжээнд байлгаж, ХГБХБ-ын бүтэц, зохион байгуулалт нь Гэр бүлийн тухай

хуулиар зохицуулагдаж буй тул ХХТХ-ын зардлын тооцоолол авч үзэх шаардлагагүй гэсэн зарчмыг баримталж зардлын тооцооллыг хийсэн.

Зардлын тооцоололд тусгагдсан бүх мөнгөн дүн нь 2015 оны үнийн түвшинд тооцсон дүн юм. Өөрөөр хэлбэл 2015 оноос хойш гарах зардлууд нь 2015 оны бодит үнээр буюу инфляцыг тооцоогүй үнээр тооцогдсон.


Зардал тооцооллын загварт ашигласан төсөөллүүд болон тоон мэдээлэл, зардлын тооцоо хийгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ, эдгээр үйлчилгээнүүд тус бүрт зардлын тооцоолол хэрхэн хийгдсэнийг нэг бүрчлэн мэдэхийн тулд зөвхөн MS Excel файл дээрх загварыг өөрийг нь судлах шаардлагатай. Гэвч сонирхсон талуудад загварын тооцоолол, үр дүнгийн талаар зарим ойлголтыг өгөх үүднээс дараагийн дэд хэсэгт загварын онцлогийн талаар, түүний дараагийн 2.3 дэд хэсэгт тооцооллын үр дүнг тус тус танилцуулсан болно.

2.2 Зардал тооцооллын загварын онцлогууд

Тооцоололд хамрагдсан болон хамрагдаагүй хүүхэд хамгааллын үйлчилгээнүүд
Ерөнхий зарчмын хувьд Зураг 2-д үзүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтаар бий болох ХГБХБ-ын тогтолцооноос гаднах байгууллагуудаас гарах боловсон хүчин, материал болон үйлчилгээний өртөг, зардлыг энэхүү тооцоололд хамруулаагүй болно. Эдгээрт:

- Боловсролын байгууллагын ажилтнууд Боловсролын тухай хуулиар хүүхэд хамгааллын үүргүүд хүлээдэг тул сургууль цэцэрлэгийн нийгмийн ажилтнууд болон багш нарын хүүхэд хамгаалалтай холбоотой гаргасан хүн хүч, цаг хугацааны болон материалын (ХХТХ-ыг хэрэгжүүлэх сургалтад оролцохоос бусад) зардлууд;
- Цагдаа болон шүүхийн байгууллагын ажилтнууд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын тохиолдлуудад зохих арга хэмжээ авах үүрэг хүлээсэн тул тэдний холбоотой гаргасан хүн хүч, цаг хугацааны болон материалын (ХХТХ-ыг хэрэгжүүлэх сургалтад оролцохоос бусад) зардлууд;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд Эмч, эмнэлгийн байгууллагууд нь эрсдэлд өртсөн хүүхэд болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэгтэй тул тэдний холбоотой гаргасан хүн хүч, цаг хугацааны болон материалын зардлууд тус тус орно.

Зураг 2: Гэр бүлийн тухай хуулиар бий болох ХГБХБ-ын бүтцийн зураглал



Тайлбар:

- ХАХНХЯ-ын сайдын багцад төсөв нь батлагддаг
- Нийслэлийн ЗД-ын багцад төсөв нь батлагддаг
- Аймгийн ЗД-ын багцад төсөв нь батлагддаг

Харин зардлын тооцоололд дараах үйлчилгээнүүдийг хамруулсан:

- Хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх
- Нөхцөл байдлын үнэлгээ
 - Үнэлгээ хийх багийн гишүүдэд олгох урамшуулал
- Аюулгүй байдлыг хамгаалах
 - Эмнэлэгт хүргэх
 - Аюулгүй орчинд байрлуулах (түр болон, удаан хугацаагаар байршуулах байруудад хүргэх, авах)
 - Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ
- Шаардлагатай үед үзүүлэх бусад тусламж
 - Архивын лавлагаа авах
 - Зураг авхуулах (бичиг баримтын)
 - Нотариатын үйлчилгээ авах
 - Төрсний гэрчилгээ авах
 - Иргэний үнэмлэх авах
- Хууль зүйн хорооны үзүүлэх болон эрх зүйн бусад үйлчилгээ
 - Шүүх хуралд оролцох
 - Өмгөөлөгч авах
 - Хорих байгууллагаас суллагдсан болон хууль зөрчсөн хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх
- Нөхөн сэргээлт, гэр бүлдээ эргэн нэгдэхэд нь туслалцаа үзүүлэх
 - ХГБХБ-ын ажилтнуудын өгөх сэтгэл зүйн зөвлөгөө
 - Гадны сэтгэл зүйчийн өгөх сэтгэл зүйн зөвлөгөө
- Гадаадын болон Монгол улсын иргэдэд хүүхэд үрчлүүлэх
- Олон нийтийг хамарсан арга хэмжээ (хурдан морины уралдаан)-ний үеэр үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээ
- Харилцаа холбоо (утас), бичиг хэрэг болон хэвлэлийн (кэйс файлын өртөг), болон шаардлагатай үед хүүхдэд өгөх цай, хоол, чихэр, жигнэмэг худалдан авах зардлууд, мөн дээрх бүх үйлчилгээг хүргэх үед гарах тээврийн зардлууд

Дээрх үйл ажиллагааны зардлаас гадна ХГБХБ-ын чадавхи, хүүхэд хамгааллын ажилтнуудын мэдлэг, мэдээллийг сайжруулах болон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн дараах арга хэмжээний зардлууд тооцоололд тусгагдсан. Үүнд:

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нэгдсэн бүртгэлийн системийг бий болгож ажиллуулах
- ХГБХБ-ын боловсон хүчний чадавх болон хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх
- ХХТХ болон хүүхэд хамгааллын талаар орон даяар ухуулга, сурталчилгааны компаниг ажил өрнүүлэх
- ХХТХ-ийг хэрэгжүүлэх болон хүүхэд хамгааллын талаарх сургалтыг ХГБХБ, цагдаа, боловсролын байгууллагын ажилтнуудад явуулах

Хавсралт 2-д зардлын тооцоололд хамрагдсан үйл ажиллагаа, арга хэмжээг дэлгэрэнгүй жагсаасан болно.

Зардлын тооцоолол ашигласан тоо баримт, төсөөллүүд

Зардлын тооцоололд ашигласан төсөөллүүдийг загварын файлын “Assumptions” хүснэгтэд тодорхой оруулсан. Тодорхой үйлчилгээг хүргэхтэй холбоотой зардлын тооцоололд ашигласан төсөөллийг тухай бүрд нь уг үйлчилгээний зардлын тооцооллын хүснэгтэд тодорхой харуулсан. Зардлын тооцоололд мэдээллийн дараах гол эх сурвалжуудыг ашигласан зарим суурь өртөг зардлыг тооцсон:

- Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг Засгийн Газрын 2012 оны 78 тоот тогтоолд заасан хэмжээг 2012-2015 оны инфляцыг тооцон нэмэгдүүлсэн дүнгээр;
- Төрийн албан хаагчдын дотоод албан томилолтын зардлыг Сангийн Сайдын 2011 оны 132 тоот тушаалд заасан хэмжээг 2012-2015 оны инфляцыг тооцон нэмэгдүүлсэн дүнгээр;
- Сумын төвөөс аймгийн төв, аймгийн төвөөс Улаанбаатар хот хүртэл явах дундаж километрийг бүсэд багтдаг аймгуудын бодит километрийн дунджаар;
- Засаг захиргааны нэгжүүдийн хүн амын тоог Үндэсний Статистикийн Газрын гаргасан 2014 оны хүн амын тооны тооцоолоор;
- Худалдан авах бараа, үйлчилгээ тус бүрийн үнийг зөвлөхийн хийсэн үнийн судалгаанд үндэслэн тус тус тооцсон.

Хүснэгт 17-д зардлын тооцооллын хувилбар тус бүрээр нийт зардлын хэмжээнд голлох нөлөө үзүүлж буй томоохон зардлуудыг тодорхойлогч хүчин зүйлсэд ямар төсөөлөл ашигласныг харуулав.

Хүснэгт 17: Зардалд нөлөөлж буй гол хүчин зүйлс

		Хувилбар 1 (Дундын)	Хувилбар 2 (Өсөлтийн)	Хувилбар 3 (Хэмнэлтийн)
ХГБХБ-уудын чадавхыг бэхжүүлэх	Хүний нөөц	Аймаг, дүүргээс дээш түвшинд 35 ажилтны орон тоо шинээр бий болно	Бүх түвшинд нийт 375 ажилтны орон тоо шинээр бий болно.	Шинэ орон тоо бий болохгүй
	Материал	Аймаг, дүүргээс дээд түвшинд 30 машин, мөн шинээр бий болсон орон тоонд дүйцэх оффисын тавилга, хэрэгсэл худалдан авна	Аймаг, дүүргээс дээд түвшинд 42 машин, мөн шинээр бий болсон орон тоонд дүйцэх оффисын тавилга, хэрэгсэл худалдан авна	Томоохон худалдан авалт хийгдэхгүй
Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрэлт		Хүүхдийн тусламжийн утас 108-аар 2015 онд хүлээн авсан хүүхэд хамгааллын холбогдолтой дуудлага нь бодит хүүхэд хамгааллын кэйс-ийн 50%-тай тэнцүү бөгөөд мэдээлэл, сурталчилгааны үр дүнд үлдэж буй 50%-г нь илрүүлднэ.	Хүүхдийн тусламжийн утас 108-аар 2015 онд хүлээн авсан хүүхэд хамгааллын холбогдолтой дуудлага нь бодит хүүхэд хамгааллын кэйс-ийн 25%-тай тэнцүү бөгөөд мэдээлэл, сурталчилгааны үр дүнд үлдэж буй 75%-г нь илрүүлднэ.	Хүүхэд хамгааллын үйлчилгээний нийт эрэлт Хүүхдийн тусламжийн утас 108-аар 2015 онд хүлээн авсан хүүхэд хамгааллын холбогдолтой дуудлагын тоотой тэнцүү байна.

2.3 Зардлын тооцооллын үр дүн

Зардлын тооцооллын үр дүнгийн хураангуйг Хүснэгт 18-д харуулав. ХХТХ-ийг хэрэгжүүлэхэд Хувилбар 1-ээр 11,5 тэрбум төгрөг, Хувилбар 2-оор 21.1 тэрбум төгрөг, Хувилбар 3-аар 4.3 тэрбум төгрөг тус тус одоогийн хүүхэд хамгаалалд зарцуулагдаж буй зардал дээр нэмж гарахаар байна.

Хүснэгт 18: ХХТХ-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хураангуй

Зардлууд	Хувилбар 1 (Дундын)	Хувилбар 2 (Өсөлтийн)	Хувилбар 3 (Хэмнэлтийн)
Нийт	11,473	21,126	4,305
Нэг удаагийн	2,314	4,536	402
Үйл ажиллагааны (урсгал)	9,159	16,590	3,903

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Өнөөгийн байдлаар хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулан жилд 9 тэрбум орчим төгрөгийг улсын төсвөөс гаргаж буй гэсэн тооцоолол хийснийг Хэсэг 1.3-д дурдсан. Тэгвэл ХХТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүүхэд хамгааллын үйл ажиллагааны нийт зардал Хувилбар 1-ээр 101 хувиар нэмэгдэж 18.2 тэрбум, Хувилбар

2-оор 184 хувиар нэмэгдэж 25.6 тэрбум, Хувилбар 3-аар 43 хувиар нэмэгдэж 12.9 тэрбум болохоор байна.

Хүснэгт 19 болон 20-д ХХТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шинээр гарах нэг удаагийн болон урсгал зардлуудыг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр харуулав. Сургалт болон Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хүүхэд хамгааллын зардлуудаас бусад зардлууд хувилбар тус бүрээр ялгаатай гарч байна. Нэг удаагийн зардлын хувьд, Хувилбар 1 болон 2-т хамгийн том зардал нь ХГБХБ-д тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл худалдан авах зардал бөгөөд энэ нь нийт нэг удаагийн зардлын 84 хувийг эзэлж байна.

Хүснэгт 19: Нэг удаагийн зардлын хураангуй

	<i>сая төгрөгөөр</i>		
	Хувилбар 1 (Дундын)	Хувилбар 2 (Өсөлтийн)	Хувилбар 3 (Хэмнэлтийн)
Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн бүртгэл	67	454	67
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (ерөнхий)	3	3	3
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (бэлгийн хүчирхийлэл)	1	2	2
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (албадан хөдөлмөр эрхлэлт)	1	2	2
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (хараа хяналтгүй хүүхдүүд)	1	2	2
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд)	-	-	-
ХГБХ байгууллагуудын чадавх бэхжүүлэх	1,951	3,779	38
Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ	17	19	15
Үрчлэлт	-	-	-
Сургалт	270	270	270
Зар сурталчилгаа	-	-	-
Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хүүхэд хамгаалал	3	6	3
Нийт	2,314	4,536	402

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Хүснэгт 20: Урсгал зардлын хураангуй

сая төгрөгөөр


	Хувилбар 1 (Дундын)	Хувилбар 2 (Өсөлтийн)	Хувилбар 3 (Хэмнэлтийн)
Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн бүртгэл	24	34	24
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (ерөнхий)	792	1,448	451
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (бэлгийн хүчирхийлэл)	311	418	115
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (албадан хөдөлмөр эрхлэлт)	101	180	60
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (хараа хяналтгүй хүүхдүүд)	196	360	112
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд)	723	723	672
ХГБХ байгууллагуудын чадавхи бэхжүүлэх	518	2,462	80
Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ	5,410	9,198	1,307
Үрчлэлт	190	489	190
Сургалт	284	284	284
Зар сурталчилгаа	167	167	167
Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хүүхэд хамгаалал	385	770	385
Нийт	9,159	16,590	3,903

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Урсгал зардлын хувьд хамгийн том зардал нь ХХТХ-д зааснаар итгэмжлэгдсэн хуулийн этгээд болон иргэдээр хийж гүйцэтгүүлэх хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний зардал бөгөөд энэ нь нийт урсгал зардлын 33-59 хувийг эзэлж байна. Харин ХГБХБ-д шинээр орон тоо бий болгохтой холбоотой зардлууд нийт урсгал зардлын 2.0-14.8 хувийг эзэлж байна.

Зураг 3-д үзүүлснээр дээрх 2 томоохон зардал нь хамгийн магадлалтай хувилбар болох Хувилбар 1-ээр нийт зардлын 22-47 хувийг эзэлж байна.

Зураг 3: Нийт зардлын бүтэц, Хувилбар 1-ээр



2.3.1 Томоохон зардлууд – Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ

Хүүхэд хамгаалалд тулгамдаж буй нэг чухал асуудал нь эрсдэлд өртсөн хүүхдийг шаардлага хангасан орчинд байршуулах газар хангалтгүйгээс олон тохиолдолд хүүхэд эргээд хүчирхийлэл үйлдэгчтэйгээ нэг дор амьдрахаас өөр аргагүйд хүрдэг явдал бөгөөд энэ нь ялангуяа Улаанбаатараас бусад газар илүү ажиглагддаг.

Хүүхдийг түр хугацаагаар байршуулан хамгаалах байрны асуудал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар зохицуулагдаж энэхүү зардлын тооцоололд тусгагдаагүй. Харин хүүхдийг удаан хугацаагаар байршуулан асрах үйл ажиллагаа ХХТХ-аар зохицуулагдсан. Өнөөгийн байдлаар хүүхэд асрах төвүүдэд амьдарч буй нийт хүүхдүүдийн 60 гаруй хувь нь хандивлагч байгууллага, иргэдийн санхүүжилт буюу баталгаагүй эх үүсвэрээс санхүүжигддэг төвүүдэд амьдарч байна. Зардлын тооцооллын Хувилбар 1 болон 2-д эдгээр төвүүдэд амьдарч буй хүүхдүүдийн зарим хэсэг нь улсаас санхүүжигддэг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгчдэд шилжих буюу тэдний одоогийн байрлаж буй төвүүдийн санхүүжилтийн зарим хэсгийг улсаас гаргадаг болохоор тооцсон. Мөн хүүхдийн хүчирхийллийн илрүүлэлт сайжирснаар хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ шаардлагатай хүүхдийн тоо тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ гэж үзсэн.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгчийн төлөөлөл болгон тус бүрдээ дунджаар 20 орчим хүүхэдтэй асрах төвүүд, болон гэртээ хүүхэд авч өсгөж хүмүүжүүлэх асралт гэр бүлүүдийг авч үзсэн. Асрах төвүүд нь 4 бүсийн төвүүд болон Улаанбаатар хотод байрлана гэж төсөөлсөн. Эдгээр төвүүд нь гэрээгээр үйлчилгээ үзүүлэгч итгэмжлэгдсэн байгууллагууд байх тул тэднийг барьж байгуулахтай

холбоотой зардал улсын төсвөөс гарахгүй, харин ийм төвүүдийг сонгон шалгаруулах, итгэмжлэх, тэдний үйл ажиллагааг зохицуулах дүрэм журмыг боловсруулах болон хяналт тавихад тодорхой хэмжээний нэг удаагийн болон урсгал зардлууд гарна. Эдгээр төвүүдэд олгох санхүүжилт нь нэгж хүүхдэд ногдох зардлаар тооцогдох бөгөөд энэ зардлыг одоо үйл ажиллагаа явуулж буй улсаас санхүүжилттэй хүүхэд асрах 2 төвийн санхүүжилт болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зардлын тооцоололд ашигласан тоо баримтад үндэслэн дараах байдлаар тооцсон болно.

Хүснэгт 21: Хүүхэд асрах төвийн нэг хүүхдэд ногдох зардал

Зардлын төрлүүд	Нэг хүүхдэд нэг өдөрт ногдох зардал
Байр	3,000
Хоол	4,500
Ариун цэвэр	600
Эрүүл мэндийн үйлчилгээ	1,500
Нийгмийн үйлчилгээ	1,000
Сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө	1,000
Хуулийн үйлчилгээ	500
Хамгаалалтын үйлчилгээ	800
Ажилтнуудын цалин, НДШ, ЭМДШ	5,293
Бусад	3,000
Нийт	22,693

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Эдгээр төвүүдийн санхүүжилт нь Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ажиллуулдаг хамгаалах байрны үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг НХҮЕГ-аас байрлуулсан хүний тоонд үндэслэн санхүүжүүлдэгтэй төстэй хэлбэрээр хийгдэнэ гэж үзсэн.

2.3.2 Томоохон зардлууд – ХГБХБ-ын чадавхыг бэхжүүлэх

Нийт зардлын хэмжээнд чухал нөлөөтэй өөр нэг зардлын төрөл бол ХГБХБ-ын чадавхыг дээшлүүлэхтэй холбоотой зардлууд бөгөөд энэ үйл ажиллагаанд Хувилбар 1-ээр 3,751 сая төгрөгийн нэг удаагийн зардал, 616 сая төгрөгийн зардал гарахаар байна. Нэг удаагийн зардлын дийлэнх хэсэг нь аймгуудын ХГБХБ-д тээврийн хэрэгсэл худалдан авахад гарах зардал юм. Хэсэг 1.1.5-д дурдсанчлан, аймгуудын ХГБХХ-ийн төсөв санхүү хүрэлцээгүй бөгөөд боловсон хүчний болон барилга байгууламжийн зардлаас бусад төрлийн томоохон зардлыг төсвийн бус эх үүсвэрээс (хандив, тусламж) санхүүжүүлэхээс өөр аргагүйд хүрдэг. ХГБХХ-үүд өөрийн гэсэн тээврийн хэрэгсэлгүй нь оффисоос гадуур ажиллах шаардлага харьцангуй их гардаг хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Эдгээрт үндэслэн Хувилбар 1, 2-д Улаанбаатар хотын болон аймгуудын ХГБХ-ийн газар, хэлтэс төвүүдэд 30-42 тээврийн хэрэгсэл худалдан авахаар тооцсон нь эдгээр хувилбаруудын нэг удаагийн зардлын 66-92 хувийг эзэлж байна.

2.4 Үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөө

ХХТХ-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодит төсөв нь тухайн үеийн төсвийн боломжоос хамаарах нь тодорхой. Гэвч зардал тооцооллын загварт хэрэгжих хамгийн өндөр магадлалтай хувилбар болох Хувилбар 1-ээс, хэрэгжүүлбэл зохих зорилтот хувилбар буюу Хувилбар 2-т таван жилийн хугацаанд аажмаар шилжвэл жил тутмын зардал ямар байхыг тооцсоныг Хүснэгт 22-д харуулав. Зардлын энэ хуваарийг гаргахдаа боломжтой үед нэг удаагийн зардлыг нэг дор биш, эхний жилүүдэд тэнцүү хэмжээгээр, эсвэл ойлгоход хялбар байдлаар хувааж тусгасан болно.

Хүснэгт 22: Хувилбар 1-ээс 2-т үе шаттайгаар шилжих үеийн зардлын хуваарь


Үйл ажиллагааны чиглэлүүд	Жил, нийт зардал (сая төгрөгөөр)				
	2016/17	2017/18	2019/20	2020/21	2021/22
Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн бүртгэл	91	129	130	127	127
Нэг удаагийн	67	105	97	93	93
Урсгал	24	24	34	34	34
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (ерөнхий)	787	950	1,116	1,282	1,448
Нэг удаагийн	3	-	-	-	-
Урсгал	783	950	1,116	1,282	1,448
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (ерөнхий)	312	337	364	391	418
Нэг удаагийн	2	-	-	-	-
Урсгал	310	337	364	391	418
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (бэлгийн хүчирхийлэл)	101	120	140	160	180
Нэг удаагийн	2	-	-	-	-
Урсгал	100	120	140	160	180
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (албадан хөдөлмөр эрхлэлт)	196	236	277	318	360
Нэг удаагийн	2	-	-	-	-
Урсгал	194	236	277	318	360
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (хараа хяналтгүй хүүхдүүд)	723	723	723	723	723
Нэг удаагийн	-	-	-	-	-
Урсгал	723	723	723	723	723
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд)	533	3,074	2,512	2,264	2,737

Нэг удаагийн	151	2,084	995	275	275
Урсгал	382	990	1,517	1,990	2,462
ХГБХ байгууллагуудын чадавх бэхжүүлэх	5,426	6,357	7,192	8,251	9,198
Нэг удаагийн	16	-	-	-	-
Урсгал	5,410	6,357	7,192	8,251	9,198
Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ	190	203	447	468	489
Нэг удаагийн	-	-	-	-	-
Урсгал	190	203	447	468	489
Үрчлэлт	554	-	-	-	-
Нэг удаагийн	270	-	-	-	-
Урсгал	284	-	-	-	-
Сургалт	167	167	167	167	167
Нэг удаагийн	-	-	-	-	-
Урсгал	167	167	167	167	167
Зар сурталчилгаа	388	388	-	-	-
Нэг удаагийн	3	3	-	-	-
Урсгал	385	385	-	-	-
Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хүүхэд хамгаалал	56	56	56	56	56
Нэг удаагийн	-	-	-	-	-
Урсгал	56	56	56	56	56
Нийт	9,525	12,740	13,124	14,208	15,903
Нэг удаагийн	515	2,192	1,091	367	367
Урсгал	9,010	10,548	12,033	13,840	15,535

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Ийм байдлаар хувааж үзэхэд хэрэгжилтийн 2 болон 3 дахь жилүүдэд нэг удаагийн зардал хамгийн өндөр байх бөгөөд энэ нь ХГБХБ-ын чадавхыг бэхжүүлэх зардалтай холбоотой. Харин нэг удаагийн зардал өндөр байх жилүүдэд урсгал зардал бага буюу нийт зардал аль болохоор бага хэлбэлзэлтэй байхаар хуваарилсныг Зураг 4-д харуулав.

Зураг 4: Хувилбар 1-ээс 2-т үе шаттайгаар шилжих үеийн зардлууд



2.5 Зардлын төрлүүд

Зардлын тооцоолол хийсэн хувилбар тус бүрээр нийт зардал болон, Хувилбар 1-ээс 2-д шилжих үеийн жилийн нийт зардлын задаргааг Хүснэгт 23, 24-д үзүүлэв.

Хүснэгт 23: Нийт зардлын задаргаа

	Хувилбар 1 (Дундын)	Хувилбар 2 (Өсөлтийн)	Хувилбар 3 (Хэмнэлтийн)
Хүний нөөц	573	2,518	135
Зөвлөхийн үйлчилгээ	5,901	10,019	1,576
Аялал, албан томилолт	121	259	92
Түлш, шатахуун	1,163	1,674	898
Тээврийн хэрэгсэл (шатахуунаас бусад)	52	66	38
Сургалт	745	754	740
Харилцаа холбоо	141	211	105
Бичиг хэрэг, хэвлэмэл материал	46	76	32
Худалдан авалт	2,574	5,305	595
Бусад	43	58	18
Хөрөнгө (ердийн)	115	188	77
Нийт	11,473	21,126	4,305

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Хүснэгт 24: Хувилбар 1-ээс 2-д шилжих үеийн нийт зардал

	2016/17	2017/18	2019/20	2020/21	2021/22
Хүний нөөц	437	1,046	1,572	2,045	2,518
Зөвлөхийн үйлчилгээ	5,902	6,871	7,924	8,966	9,978
Аялал, албан томилолт	121	129	216	250	259
Түлш, шатахуун	1,163	1,280	1,408	1,555	1,674
Тээврийн хэрэгсэл (шатахуунаас бусад)	52	54	38	64	66
Сургалт	745	187	189	191	193
Харилцаа холбоо	141	157	176	194	211
Бичиг хэрэг, хэвлэмэл материал	46	53	62	69	76
Худалдан авалт	774	2,795	1,344	652	683
Бусад	30	36	45	51	58
Хөрөнгө (ердийн)	115	132	149	171	188
Total	9,525	12,740	13,124	14,208	15,903

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Зардлын задаргааг хийсэн ангилал нь зөвхөн тухай зардлын хэмжээний талаар баримжаа өгөх зорилгоор хийгдсэн бөгөөд зарим тохиолдолд зардлыг ямар ангилалд

хамруулах эсэх нь тодорхой бус байдаг. Жишээлбэл, аймгийн ХГБХБ-ын ажилтан сургалтад хамрагдахаар Улаанбаатар хотод ирсэн тохиолдолд түүний унааны зардлыг сургалтын зардал болон тээврийн хэрэгслийн зардлын алинд нь ч оруулж болно.

Хүснэгт 23, 24-д харуулсан “хүний нөөцийн” зардалд ХГБХБ-ын шинээр бий болох орон тоонд ажиллах ажилтнуудын үндсэн болон нэмэгдэл цалин, НДШ, ЭМДШ, “зөвлөхийн үйлчилгээ”-ний зардалд програм хангамж хөгжүүлэгч, сэтгэл зүйч, өмгөөлөгч зэрэг зөвлөхүүдээс гадна Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгчдэд нэг хүүхдэд ногдох зардалд суурилсан төлбөрүүд “аялал, томилолтын” зардалд төрийн албан хаагчдын хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой албан томилолтын зардлууд ихэвчлэн орсон. “Түлш, шатахууны” зардлыг явах бодит километр болон тээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын дунджийг ашиглан тооцсон ба “тээврийн хэрэгслийн (шатахуунаас бусад)” зардалд төрийн албан хаагчид болон зөвлөхүүд сургалт, хяналт зэрэг ажлаар байнга оршин суудаг газраасаа өөр газарт явах зардлууд орсон. “Сургалт”-ын зардалд хүүхэд хамгааллын чиглэлээр ХГБХБ, хууль сахиулах болон боловсролын байгууллагын ажилтнуудад сургалттай холбоотой бүх зардал (сургалт, тээвэр, унаа, байр, хоол) багтсан. “Харилцаа холбоо”-ны зардлыг утасны 1 минутын ярианы төлбөрийг 70 төгрөгөөр тооцож тусгасан.

“Бичиг хэрэг, хэвлэмэл материал”-ын зардлыг нэг хүүхдийн кэйс хөтлөлт дунджаар 50 хуудастай, 6925 төгрөгийн өртөгтэй байхаар тооцоолсон. “Худалдан авалт” ангилалд зардалд тээврийн хэрэгсэл, шинээр бий болох орон тоонд ажиллах ажилтнуудын хэрэглэх оффисын тавилга зэрэг томоохон худалдан авалтуудаас гадна хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх явцад зарим тохиолдолд шаардагддаг хүүхдүүдэд өгөх цай хоол, чихэр жигнэмэг зэрэг жижиг худалдан авалтын хот хөдөөгөөр ялгаатай үнээр тооцсон зардлууд орсон. Харин “бусад” ангилалд зорилтот бүлэг болон олон нийтэд хүүхэд хамгааллын талаар явуулах нөлөөллийн ажилд шаардагдах зурагт хуудас, хэвлэмэл материалын зардал багтсан.

2.6 Хувьсах зардал

Монгол улсад төрөөс үзүүлэх зарим үйлчилгээний төсөв нэг хүнд ногдох хувьсах зардалд тулгуурлан тооцоологддог. Энд тухайлбал нэг сурагчид ногдох хувьсах зардалд суурилсан дунд сургуулийн төсөв, халамж авагч иргэдийн тоонд суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээний төсөв, байнга оршин суугч иргэдийн тоонд суурилсан орон нутгийн төсөв зэргийг дурдаж болно. Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан зарим байгууллагын саналыг үндэслэн хүүхэд хамгааллын зарим үйлчилгээний хувьсах зардлыг тооцсоныг Хүснэгт 25-д харуулав.

Хүснэгт 25: Нэг хүүхдэд ногдох хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлын тооцоолол, улсын дунджаар

	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3
Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ			
Ерөнхий	192	175	219
Бэлгийн хүчирхийлэл	1,161	780	861
Албадан хөдөлмөр эрхлэлт	279	249	329
Хараа хяналтгүй хүүхдүүд	183	168	208
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд	76	76	71
Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ	6,710	6,729	7,297
Үрчлэлт	106	210	106
Хүүхдийн хууль зүйн хорооны үйлчилгээ	159	159	159

Эх сурвалж: Зохиогчийн тооцоолол

Хүснэгт 25-д харуулсан зардлууд нь зардлын тооцоололд тусгагдсан бүх төрлийн зардлууд биш харин, нэг хүүхдэд суурилсан хувьсах зардлыг нь тооцох боломжтой зардлууд юм. Өөрөөр хэлбэл эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн бүртгэл, зар сурталчилгаа, сургалт, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үеийн хүүхэд хамгааллын зардлууд дээрх хүснэгтэд тусгагдаагүй болно.

Энэхүү зардал нь зөвхөн нийслэл, дүүрэг, аймгийн түвшинд ХГБХБ болон сум хорооны нийгмийн ажилтнуудаас үзүүлэх, зардал тооцооллын загварын “Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ” хэсэгт зардлыг нь тооцсон үйлчилгээний дундаж зардал юм.

Мөн энд тооцсон хувьсах зардал нь газарзүйн байршил болон хот хөдөөгөөр ялгаатай байхыг тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл хүн амын нягтаршил, бараа үйлчилгээний өртөг өндрөөс шалтгаалан алслагдсан аймаг сумдад тодорхой үйлчилгээг хүргэх зардал нь ижил төрлийн үйлчилгээг Улаанбаатар хотод хүргэх зардлаас өндөр байх тохиолдлууд гарна.

ХЭСЭГ 3: ДҮГНЭЛТ

ХХТХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийн энэхүү тооцоолол нь олон улсад хэрэглэгддэг сайн жишгүүдийг ашигласан байдал болон зардал нэг бүрээр нарийвчилсан түвшинд авч үзсэн байдлаараа зохиогчдын мэдэж буйгаар Монгол улсад хийгдэж буй анхны тохиолдол юм. Иймээс энэхүү зөвлөх үйлчилгээний ач холбогдол нь зөвхөн ХХТХ-ийн зардлыг тооцооллыг хийснээрээ төдийгүй Монгол улсын Төрөөс цаашид гаргах аливаа шийдвэрийн санхүүгийн үр дагаврыг тооцох жишиг тогтоосноороо ач холбогдолтой гэж үзэж байна.

ХХТХ-ыг хэрэгжүүлэх зардлын тооцооллыг “хэмнэлтийн”, “дундын” болон “өсөлтийн” буюу бага, дунд, их зардалтай гурван хувилбараар тооцсон. Тооцооллоос үзэхэд ХХТХ-ыг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний далайцаас хамаарч 0.4-4.5 тэрбум төгрөгийн нэг удаагийн зардал болон жилийн 3.9-16.6 тэрбум төгрөгийн урсгал зардал гарахаар байна. Энэ нь одоогоор улсаас хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зарцуулж буй 9 тэрбум төгрөг дээр нэмж гарах дүн юм. Мөн энэ зардал нь зөвхөн хүүхэд хамгаалалтай холбоотой ХГБХ-ийн системийн байгууллагаас гарах зардал бөгөөд Хэсэг 2.1-д дурдсанчлан энд цагдаа, шүүх, эмнэлгийн байгууллагууд зэрэг ХГБХ-ийн үндсэн тогтолцооны гадна орших байгууллагуудаас гарах зардал багтаагүй.

Зөвлөх үйлчилгээ хийгдсэн цаг хугацаанаас шалтгаалан зардлын тооцооллыг ХХТХ-ын УИХ-аар батлагдсан хувилбар бус, ХХТХ-ийн төслийн 2015 оны 12 сарын 1-ний байдлаарх хувилбарт үндэслэн хийсэн. Хэдий тийм боловч УИХ-аар батлагдсаны дараа зардлын тооцооллыг дахин хянан үзэж, хуульд заагдсан бүх гол үйлчилгээнүүдийг зардлын тооцоололд хамруулсан болно.

Зардал тооцооллын загвар нь үндсэн параметрууд болон тэдгээр параметрийг тодорхойлогч өгөгдлийг өөрчилсөн тохиолдолд зардлын тооцоолол автоматаар шинэчлэгдэж байхаар зохион байгуулагдсан. Энэ нь ойрын хугацааны төсвийн орчин тодорхойгүй өнөөгийн нөхцөлд СЯ болон ХАХНХЯ-ны ажилтнуудад хэрэг болох онцлог юм. Жишээлбэл, төрийн албан хаагчдын одоо мөрдөгдөж буй цалингийн сүлжээнд өөрчлөлт орсон тохиолдолд тооцооллын загварт тодорхой нэг хэсэгт цалингийн шинэчлэгдсэн мэдээллийг оруулахад нийт зардлын дүн шинэчлэгдэн тодорхойлогдоно. Мөн хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхдийн тоо нэмэгдсэн тохиолдолд шинэ өгөгдлийг загварын тодорхой хэсэгт оруулж тооцооллыг шинэчилж болно.

Өмнөх хэсгүүдэд дурдсанчлан, ХХТХ-ийн дагуу явагдах үйл ажиллагаа нь нь Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулагдах харилцаатай харилцан уялдаатай. Жишээлбэл ХХТХ-ийн дагуу Төрөөс хүргэх хүүхэд хамгааллын үйлчилгээ

нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар бий болох интитуцийн бүтцээр дамжин хүргэгдэнэ. Эдгээр хуулиуд нь мөн хүүхэд хамгаалалтай шууд холбоотой гадаадын болон Монгол улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх зэрэг харилцааг зохицуулдаг.

ХХТХ-ын явагдах хүүхэд хамгаалал нь Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудад заасан хүүхдийн эрх, сайн сайхан байдлыг хэмжих олон үзүүлэлтийн зөвхөн нэг хэсэг нь юм. Түүнчлэн хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн хамгаалал нь гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэлтэй шууд холбоотой бөгөөд эдгээр үйл ажиллагаанууд бүгд нэг байгууллагаар буюу ХГБХБ-аар дамжин хэрэгжиж байгаа нөхцөлд үйл ажиллагаа тус бүрд зарцуулагдаж буй төсөв зардлыг ялгаж тооцох нь амаргүй. Эдгээрт үндэслэн хүүхэд, гэр бүлийн холбогдолтой шинээр батлагдсан буюу шинэчлэн найруулагдах бүх хуулийг хамарсан зардлыг тооцооллыг хийх нь төсөв зохиогчдын хувьд ач холбогдолтой байх болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Лхагвадоржийн Ариунаа (2012). 2011 онд батлагдсан Төсвийн тухай шинэ хуульд хийсэн шинжилгээ 2011, Улаанбаатар, Монгол улс

Барбертон К., Картер, Ж., Абдолл, К. (2014). 2011 онд батлагдсан Лесота улсын Хүүхэд Хамгаалал, Халамжийн тухай хуулийн төсөв, зардлын тооцоолол, Лесота улсын Хууль Зүйн Яаманд зориулж бэлтгэсэн тайлан, Масеру, Лесота улс

Төсвийн Шинжилгээний Нэгж, Мониторингийн хэлтэс, Монгол Улсын Их Хурал. (2013). Төсвийн Зардлын Нормууд,

Хууль Зүйн Яам. (2014). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн санхүүгийн үр дагавар, Улаанбаатар, Монгол улс


ХТҮГ, Улаанбаатар хотын ХГБХХ. (2014). Хүүхдийн халамж, асрамжийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал. Улаанбаатар, Монгол улс

Доржпүрэвийн Олончимэг ба бусад (2014). Хүүхэд хамгааллын Системийн Зураглал, Улаанбаатар, Монгол улс


Улаанбаатар хотын ХГБХХ, ММСГ ХХК. (2014). Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа, Улаанбаатар, Монгол улс

ХАВСРАЛТ 1: ХҮҮХЭД ХАМГААЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ


Зураг 5: Хамгаалал шаардлагатай хүүхдэд үйлчилгээ хүргэх процесс



Зураг 6: Монгол улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх процесс /Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсанаар/



Зураг 7: Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх процесс /Гэр бүлийн тухай хуульд тусгагдсанаар/



ХАВСРАЛТ 2: ЗАРДЛЫН ТООЦООЛОЛД ХАМРАГДСАН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД

#	Хуулийн зүйл заалт	Зардлын тооцоололд тусгагдсан эсэх	Тайлбар	Зардал тооцоололд хэрхэн тусгах
Бүлэг 1: Нийтлэг үндэслэл				
1	Хуулийн зорилт	Үгүй		
2	Хүүхэд хамгааллын зарчим, тогтолцоо	Үгүй		
3	Хуулийн үйлчлэх хүрээ	Үгүй		
4	Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Үгүй		
Бүлэг 2: Гэр бүл, нийгэм дэх хүүхэд хамгаалал				
5	Гэр бүл дэх хүүхэд хамгаалал	Үгүй	ЗГ-т санхүүгийн үүрэг оногдуулаагүй	
6	Боловсролын салбар дах хүүхэд хамгаалал	Үгүй	БТХ*, ГБХТТХ**-д хамаарна	
7	Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал	Үгүй	ГБХТТХ**-д хамаарна	
8	Хэвлэл, мэдээлэл цахим орчин дахь хүүхэд хамгаалал	Тийм		Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээний зардал
9	Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал	Тийм		Морин уралдааны үеэр унаач хүүхдүүдийг хамгаалах зардал
Бүлэг 3: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ				
10	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	Үгүй	Хариу үйлчилгээний, нэр төрлийг тодорхойлсон	
11	Мэдээлэл хүлээн авах	Тийм		Бүртгэлийн систем байгуулах, мэдээлэл хүлээн авах утас ажиллуулах
12	Нөхцөл байдлын үнэлгээ хийх	Тийм		Тээвэр, харилцаа холбоо, багийн гишүүдийн урамшуулал, аюулгүй газар хүргэх, эмнэлгийн тусламжид хүргэх, холбон зуучлах үйлчилгээ, шүүхийн процесст оролцох

13	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах	Тийм		Асрах хувилбарт үйлчилгээтэй холбоотой зардлууд
14	Дэмжих, холбон зуучлах үйлчилгээ	Тийм		Нотариатын, архивын лавлагаа авах г.м
15	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажил үйлчилгээ	Тийм		Хууль, эрх зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зардлууд
16	Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх	Тийм		Эцэг эхэд нь сургалт явуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах үйлчилгээний зардлууд
Бүлэг 4: Хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа				
17	Төрийн байгууллагын хамтын ажиллагаа	Үгүй	Зардал шаардахгүй	
18	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа	Тийм	Төрийн хүлээх үүрэгтэй холбоотой зардал өөр хэсгүүдэд тооцогдсон	
19	Хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа	Тийм	Төрийн хүлээх үүрэгтэй холбоотой зардал өөр хэсгүүдэд тооцогдсон	
20	Нийгмийн ажилтны эрх зүйн байдал	Үгүй	Зардал шаардахгүй	
Бүлэг 5: Хяналт, Шинжилгээ, Үнэлгээ, Санхүүжилт				
21	Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт	Үгүй	Төрийн хүлээх үүрэгтэй холбоотой зардал өөр хэсгүүдэд тооцогдсон	
22	Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ	Үгүй	Төрийн хүлээх үүрэгтэй холбоотой зардал өөр хэсгүүдэд тооцогдсон	
23	Хүүхэд хамгааллын санхүүжилт	Үгүй	Төрийн хүлээх үүрэгтэй холбоотой зардал өөр	

			хэсгүүдэд тооцогдсон	
Бүлэг 6: Бусад зүйл				
24	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Үгүй	Зардал шаардахгүй	
25	Хууль хүчин төгөлдөр болох	Үгүй	Зардал шаардахгүй	

* БТХ – Боловсролын тухай хууль ** ГБХТХ – Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль